

# МОНГОЛ УЛСЫН ХҮНИЙ ХӨГЖЛИЙН ИЛТГЭЛ 2016



50  
YEARS

Ирээдүйн сайн сайхны төлөө:  
Монгол Улсын хөгжилд залуучуудын оролцоо

**ХУРААНГУЙ**





Монгол Улсын Хүний хөгжлийн үндэсний энэхүү зургаа дахь илтгэлийн нүүрний зургаар улс орныхоо ирээдүйн хөгжилд залуучуудын оролцоо хэрхэн чухал болохыг илэрхийлэхийг зорьлоо. Монгол гэрээр хүний хөгжилд суурилсан залуучуудын талаарх төр засгийн бодлогыг дөрвөн гол тулгуур чиглэлээр судлан зөвлөмж болгосон илтгэлийн 7.1 дүгээр зургийн утгыг илэрхийлэв. Гэрийн ханыг нийгмийн янз бүрийн бүлгийн төлөөлөл болох залуучууд хамтын хүчээр бат бэх тулж байна. Гэрийн тооноор солонгорон цагарч буй олон өнгийн туяа нь дэлхий нийтийн өмнө тавигдаж буй Тогтвортой хөгжлийн 17 зорилгыг хэрэгжүүлэхийн чухлыг бидэнд сануулж буй юм. Хүнд ээлтэй, найдвартай, хүртээмжтэй, тогтвортой үйлдвэрлэл, дэд бүтцийг хөгжүүлэх, инновац шинэчлэлийг хөхиүлэн дэмжих тухай тогтвортой хөгжлийн есдүгээр зорилгын илэрхийлэл, баяр цэнгэл, баатарлаг зориг сүр жавхаа илэрхийлсэн улбар шар өнгөөр дэвсгэр хийлээ.

# **МОНГОЛ УЛСЫН ХҮНИЙ ХӨГЖЛИЙН ИЛТГЭЛ 2016**

**Ирээдүйн сайн сайхны төлөө:**

**Монгол Улсын хөгжилд залуучуудын оролцоо**

**ХУРААНГУЙ**

Энэхүү илтгэл нь НҮБ–ын Хөгжлийн хөтөлбөр, Монгол Улсын Засгийн газрын албан ёсны байр суурийг илэрхийлээгүй болно. Илтгэлийг ашгийн бус зорилгоор хуулбарлах, олшруулж тараахыг зөвшөөрнө.

Copyright © 2016

Монгол улс дахь Нэгдсэн Үндэстний Байгууллагын Хөгжлийн хөтөлбөр

Нэгдсэн Үндэстний Байгууллагын (НҮБ) байр, НҮБ–ын гудамж 14, Сүхбаатар дүүрэг, Улаанбаатар 14201, Монгол Улс

Нэгдсэн Үндэстний Байгууллагын Хөгжлийн хөтөлбөр

Цахим шуудан: [registry.mn@undp.org](mailto:registry.mn@undp.org)

Цахим хаяг: <http://www.mn.undp.org/>

# АЖЛЫН БАГ

---

## Суурь судалгааг бэлтгэсэн (овгийн цагаан толгойн үсгийн дарааллаар)

Боожоогийн Лакшми, Захирал/Судалгааны багийн ахлагч, Эдийн засгийн бодлого, өрсөлдөх чадварын судалгааны төв

Дастин Бартер, НҮБ-ын Хүн амын сангийн Залуучуудыг чадавхижуулах болон нөлөөллийн асуудал хариуцсан мэргэжилтэн

Даян-Очирын Хишигбуян, Боловсролын асуудлаарх судлаач

Цэгмэдийн Даваадулам, НҮБ-ын Хөгжлийн хөтөлбөрийн Засаглалын багийн ахлагч

Цэрэндоржийн Эрдэнэчимэг, Жендэр, хөгжлийн бэрхшээлтэй иргэд, ЛГБТ залуучуудын асуудлаарх судлаач

Шагдарсүрэнгийн Оюунбилэг, Эрүүл мэндийн асуудлаарх судлаач

## Илтгэлийг боловсруулсан баг

Саураб Синха, Багийн ахлагч, НҮБ-ын Хөгжлийн хөтөлбөрийн ахлах эдийн засагч асан

Хорлоогийн Энхжаргал, Үндэсний зөвлөх

Алтанхуягийн Гэрэлтуяа, Статистикийн шинжээч

## Хянан тохиолдуулсан

Роберт Зиммерман

## Хүн амын хөгжил, нийгмийн хамгааллын яам

Содномзундуйн Эрдэнэ, УИХ-ын гишүүн, Засгийн газрын гишүүн, Сайд

Гочоогийн Нарангэрэл, Төрийн нарийн бичгийн даргын үүрэг гүйцэтгэгч

Дүгэрийн Амарсайхан, Хүн амын хөгжлийн бодлогын хэрэгжилтийг зохицуулах газрын дарга

Цоодолын Болормаа, Гадаад хамтын ажиллагааны хэлтсийн дарга

Гантулгын Мөнхтөвшин, Залуучуудын хөгжлийн хэлтсийн дарга

Цэнзээгийн Мягмарсүрэн, Залуучуудын хөгжлийн хэлтсийн мэргэжилтэн

Бат-Очирын Энхсайхан, Залуучуудын хөгжлийн хэлтсийн мэргэжилтэн

## Нэгдсэн Үндэстний Байгууллагын Хөгжлийн хөтөлбөр (НҮБХХ)

Биата Транкман, НҮБ-ын Суурин зохицуулагч, НҮБ-ын Хөгжлийн хөтөлбөрийн Суурин төлөөлөгч

Сезин Синаноглу, НҮБ-ын Суурин зохицуулагч, НҮБ-ын Хөгжлийн хөтөлбөрийн Суурин төлөөлөгч асан

Даниела Гаспарикова, Орлогч Суурин төлөөлөгч

Томас Эриксон, Орлогч Суурин төлөөлөгч асан

Жамбалын Должинсүрэн, Хүний хөгжил, Мянган хөгжлийн зорилтын хөтөлбөрийн багийн ахлагч

Пунцагийн Цэцгээ, Хүний хөгжил, Мянган хөгжлийн зорилтын хөтөлбөрийн шинжээч

Сумхүүгийн Сюзанна, Үндэсний Хүний хөгжлийн илтгэлийн судалгааны туслах ажилтан

Пүрэвдоржийн Жаргалсайхан, Хэвлэл, мэдээллийн ажилтан

## Орчуулагч

Баярын Батзориг

## Инфографик

Ганбаатарын Хангай, Лувсандоржийн Хануй, Ганбаатарын Батбуян

## Хэвлэлийн дизайн

Алтанхуягийн Чинбат



Дэлхийн улс орнууд, тэр дундаа Ази тивийн улсууд хөгжлийнхөө зорилгыг хүнээ хөгжүүлэхэд чиглүүлж “Хүний хүчээр хөгжинө”, “Хүний төлөө хөгжинө” гэж тодорхойлж байна. Үүний тулд өсвөр үе, залуучуудын авьяас, оюун ухаан, бие бялдарын чадамж боломжийг нээн хөгжүүлэх замаар бие, хэл, сэтгэлгээний өндөр чадамжтай, бүтээлч, өрсөлдөх чадвартай, шинийг эрэлхийлэгч, санаачлагатай иргэнийг бэлтгэн төлөвшүүлэхийг зорих болжээ.

Аливаа улс оронд залуучууд бол ирээдүйн том нөөц, ихийг бүтээх асар их хүч байдаг. Залуучуудын хөгжилд хөрөнгө оруулалт хийх нь хүний хөгжлийн томоохон үр дүн болох төдийгүй ядуурлаас ангижрах, ажилгүйдлийг бууруулах зэрэг нийгэм, эдийн засгийн томоохон өөрчлөлтийг авчирдаг.

Дэлхий дээр арван хүн тутмын долоо нь 0-34 хүртэлх насны иргэнтэй улс орон маш цөөн билээ. Нийт хүн амын 34.9 хувийг 15-34 насны залуус эзэлдэг манай улсад залуучуудын эрхийг хангах, тэдний хөгжилд чиглэсэн хөрөнгө оруулалт хийх, бүх шатан дахь залуучуудын бодит оролцоог нэмэгдүүлэх, залуучуудын байгууллагуудыг үндэсний хэмжээний үйл ажиллагаанд татан оролцуулах, залуучуудын амьдралын чанарыг сайжруулах, амьдралын түвшинг нэмэгдүүлэх хэрэгцээ, шаардлага бидэнд байна.

Үүний тулд залуучуудын оролцоог бүхий л талаар нэмэгдүүлж эрхийг олгох замаар шийдвэрээ өөрсдөө гаргаж, өөрсдөө хариуцлагаа ухамсарладаг нийгмийг цогцлоож, боловсролын чанарын шинэчлэлийг дэмжиж залуучуудыг хөгжүүлж, мэдлэг, боловсролоо чадварлаг ашиглан эд баялгийг буй болгох замд хөтлөх нь бидний үүрэг юм.

Энэ удаагийн Монгол Улсын Хүний хөгжлийн зургаадугаар илтгэл нь “Ирээдүйн сайн сайхны төлөө: Монгол Улсын хөгжилд залуучуудын оролцоо” сэдвээр

боловсруулагдсан нь цаг үеэ олсон зөв сэдэв болсон төдийгүй хүн амын бүлгүүдээс улс орны хөгжилд голлох байр суурийг эзэлдэг залуучуудын өмнө тулгамдаад буй асуудлуудыг сонгон авч судалгаа шинжилгээнд үндэслэн өнөөгийн бодит байдал болон засгийн газраас авч хэрэгжүүлсэн үйл ажиллагааны үр дүнг тодорхойлсон нь уг баримт бичгийн онцлог боллоо.

Мөн нэг зүйлийг нэмж хэлэхэд 2014 онд Азербайжан Улсын нийслэл Баку хотноо дэлхийн өнцөг булан бүрээс ирсэн бодлого боловсруулагчид, шийдвэр гаргах түвшний төлөөлөгчдийг оролцуулсан “Дэлхийн залуучуудын бодлогын асуудлаарх анхдугаар форум”-ыг зохион байгуулж, улс орон бүр залуучуудын хөгжлийн нэгдсэн бодлоготой байх тухай зөвлөмжийг гаргасан.

Үүний дагуу манай яамны зүгээс Монгол Улсын төрөөс залуучуудын хөгжлийн талаар баримтлах бодлогыг боловсруулах зорилгыг тавьж 2015 оноос эхлэн баримт бичгийг боловсруулах ажилд ороод байна. Уг бодлогын баримт бичгийн зорилгод нийцэх нотолгоонд суурилсан зорилтуудыг дэвшүүлэхэд Хүний хөгжлийн үндэсний зургаа дахь илтгэлийн суурь судалгаа, санал зөвлөмжүүд голлох байр суурийг эзэлж байгаа билээ.

Монгол Улс дахь НҮБ-ын Хөгжлийн хөтөлбөрийн дэмжлэгтэйгээр манай улсын чадварлаг эрдэмтэн судлаачид, олон улсын туршлагатай зөвлөхүүдийн хамтын хүч хөдөлмөр, ард иргэдтэйгээ нээлттэй хэлэлцэний үндсэн дээр бүтэж буй Хүний хөгжлийн үндэсний зургаа дахь илтгэл нь хүний хөгжлийн асуудал Монгол Улсын хөгжил дэвшилд гол үүрэгтэй гэдгийг дахин баталж чадсан баримт бичиг болж байгаагийн зэрэгцээ залуучуудын хөгжлийн талаар баримтлах бодлогыг хэрэгжүүлэх, нотолгоонд суурилсан оновчтой шийдвэр гаргахад суурь болохуйц баримт бичиг болж чадлаа.

Монголын залуучууд ямагт тэнгэрлэг, хийморлиг, цог золбоотой байж хүчирхэг Монголын өөдрөг ирээдүйг бүтээж, дэлхийн хөгжлийг тодорхойлохын өлзийтэй ерөөлийг дэвшүүлье.

Содномзундуйн Эрдэнэ

Хүн амын хөгжил, нийгмийн хамгааллын сайд



НҮБ-ын Хөгжлийн хөтөлбөр нь Хүний хөгжлийн үндэсний илтгэлийг боловсруулах асуудлаар дэлхийн улс орнуудтай хамтран ажилладаг. Баялаг мэдээ мэдээллийг агуулсан энэхүү хараат бус оюуны бүтээлүүд нь хүний хөгжилтэй холбоотой өнөөгийн болоод ирээдүйн бодлогын асуудлыг судлан зөвлөмж гаргадаг. Илтгэл бүр Дэлхийн Хүний хөгжлийн анхдугаар илтгэлийн “Аливаа улс үндэстний жинхэнэ баялаг нь хүмүүс мөн” гэсэн энгийн бөгөөд гүн гүнзгий агуулга бүхий тунхаглалыг үндэс болгодог.

Монгол Улс Хүний хөгжлийн үндэсний илтгэлээ анх 1997 онд гаргаснаас хойш таван илтгэлийг боловсруулж нийтийн хүртээл болгожээ. Өнөөдөр би “Ирээдүйн сайн сайхны төлөө: Монгол Улсын хөгжилд залуучуудын оролцоо” сэдэвт Монгол Улсын хүний хөгжлийн зургаа дахь илтгэлийг толилуулж байгаадаа таатай байна.

2015 оны байдлаар Монгол Улсын хүн амын 34.9 хувийг 15-34 насны залуучууд бүрдүүлж байгаа бөгөөд тэд хөдөлмөрийн насны хүмүүсийн нилээд хувийг эзэлж байгаагаас үзэхэд энэхүү илтгэлийн сэдэв цаг үеэ олсон чухал ач холбогдолтой юм. Өнөөгийн Монголын залуучууд ардчилсан нийгэмд, шинэ үзэл бодол, эрч хүч, хүсэл тэмүүлэлтэй өсч торниж буй анхны үеийнхэн билээ. Тэд асуудлыг дэлхийн хэмжээнд сэтгэх чадвартай, урьд өмнөхөөс илүү харилцаа холбоотой, өөрчлөлт шинэчлэлийн зоримог хүч юм. Энэхүү эрч хүчийг Монголын нийт иргэдийн тогтвортой, шударга, баялаг ирээдүйг бүтээхэд дайчлан чиглүүлэх нь чухал байна.

Илтгэл залуучуудын өмнө нээгдэж буй боломж, тулгарч байгаа сорилтуудад дүн шинжилгээ хийжээ. Үндэсний түвшинд Монгол Улс нь хүний хөгжлийн индексээр (ХХИ) ихээхэн дэвшилд хүрч, 2015 онд анх удаа хүний хөгжлийн түвшин өндөртэй орнуудын эгнээнд шилжлээ. Гэсэн хэдий ч олон арван залуус анхаарлын гадна байна. Эмзэг, өртөмтгий бүлэгт хамаарагдах зарим залуус тэгш бус байдал, гадуурхлын янз бүрийн хэлбэрт өртөх эрсдэлтэй байна. Залуучуудын улс төрийн оролцоо хангалтгүй, шийдвэр гаргах түвшинд тэдний манлайлал хязгаарлагдмал байна. Залуу хүмүүсийн

хэрэгцээ шаардлага, хүсэл тэмүүлэлд илүү анхаарал хандуулж, залуучуудын онцлог хэрэгцээг тодорхойлох, шийдвэрлэх арга замыг тогтооход тэдний оролцоог хангах шаардлагатай байгааг илтгэлд тэмдэглэжээ. Мөн Монголын залуучуудыг улс орныхоо хөгжлийн өөрчлөлт шинэчлэлийн шийдвэрлэх хүчин болохоо харуулахыг тус илтгэл уриалжээ.

Монгол Улсын хөгжилд залуучуудыг татан оролцуулах нь нэн чухал. Ядуурлыг устгах, дэлхий ертөнцөө хайрлан хамгаалах, бүх нийтийн хөгжил дэвшлийг хангахад чиглэгдсэн Нэгдсэн Үндэстний Байгууллагын Тогтвортой хөгжлийн зорилгууд, Монгол Улсын 2030 он хүртэлх Тогтвортой хөгжлийн үзэл баримтлалыг хэрэгжүүлэх гол хүч нь залуучууд бөгөөд цаашид ч тэд манлайлагч байх болно. Чанартай боловсролын хүртээмжийг нэмэгдүүлэх, ажилгүйдлийг бууруулах, улс төр, засаглалын үйл ажиллагаанд залуучуудын идэвхтэй оролцоог дэмжих, тэдэнд амьдралын эрүүл хэв маягийг хэвшүүлэх зэрэг нь дээрх зорилгыг хэрэгжүүлэхэд нэн чухал ач холбогдолтой.

Энэхүү илтгэлийн гол хэрэглэгчид нь залуучууд, бүх түвшний бодлого боловсруулагчид, шийдвэр гаргагчид, иргэний нийгмийн болон судалгаа шинжилгээний байгууллагууд, хувийн хэвшлийнхэн, олон улсын хөгжлийн түншүүд, ард иргэд юм. Илтгэл нь монголын залуучуудад тулгарч байгаа сорилтуудыг шийдвэрлэх талаар үндэсний хэмжээнд хэрэгжүүлж байгаа өнөөгийн хүчин чармайлтад хувь нэмэр оруулна гэдэгт найдаж байна. Энэхүү илтгэлийг олон салбарын төлөөллийн оролцоотой хийсэн цуврал хэлэлцүүлгүүд, мэргэжилтнүүдийн зөвлөгөө тусламжтайгаар үндэсний болоод олон улсын судлаачдын баг боловсруулжээ. Энэ завшааныг ашиглан тус илтгэлийг боловсруулахад хувь нэмэр оруулсан бүх хүмүүст талархал илэрхийлье.

Илтгэл нь залуучуудын өмнө тулгарч буй асуудал, хүний хөгжил, залуучуудын төлөөх хөгжлийг түргэсгэхэд оролцогч олон байгууллагуудын гүйцэтгэх үүргийн талаар өргөн яриа хэлэлцүүлэг өрнүүлэх үндэслэл болно гэдэгт найдаж байна. Монголын залуучууд энэхүү илтгэлийг өөрийн болгож, боломж чадавхиа бүрэн дайчилж, улсынхаа ирээдүйн хөгжилд даацтай хувь нэмэр оруулна гэдэгт гүнээ итгэж байна.

Биата Транкман

НҮБ-ын Суурин зохицуулагч бөгөөд НҮБ-ын Хөгжлийн хөтөлбөрийн Суурин төлөөлөгч

# АГУУЛГА

## АЖЛЫН БАГ

## ӨМНӨХ ҮГ

## ӨМНӨХ ҮГ

## ТАЛАРХАЛ

## ЕРӨНХИЙ ТОЙМ

### БҮЛЭГ 1. УДИРТГАЛ

Хүний хөгжлийн үндэсний илтгэл, түүний үндсэн зорилго

Илтгэлийн судалгааны хүрээ, бүтэц

Хүний хөгжлийн үндэсний илтгэлд хамраагүй асуудал

Монголын залуучуудын нөхцөл байдал

Монголын залуучууд: гол онцлог

Залуучууд нь хүн амын томоохон бөгөөд онцлог бүлэг болох нь

Залуучуудын асуудлыг үндэсний болон салбарын бодлогын хүрээнд шийдвэрлэж байгаа нь

### БҮЛЭГ 2. ХҮНИЙ ХӨГЖИЛ

Удиртгал: Хүний хөгжлийг хэмжих нь

Хүний хөгжилд үзүүлэх эдийн засгийн өсөлтийн нөлөө

Хүний хөгжлийн бүрэлдэхүүн үзүүлэлтүүд

Боловсролын индекс ба боловсролын хүртээмж

Дундаж наслалтын индекс ба залуучуудын эрүүл мэнд

Тэгш бус байдлын нөлөөг тооцсон хүний хөгжлийн индекс

Жендерийн тэгш бус байдлыг хэмжих нь

Олон хэмжүүрт ядуурал

Дүгнэлт

### БҮЛЭГ 3. ЧАДАМЖИЙГ ХӨГЖҮҮЛЭХ НЬ

Удиртгал: Залуучуудын чадамжийг хөгжүүлэх нь

Залуучуудын боловсрол

Дунд боловсрол

Хот-хөдөө, баян-ядуу болон жендерийн ялгаа

Хөгжлийн бэрхшээлтэй залуучуудын сургуульд хамрагдалт

Гол сорилтууд

Дээд боловсрол

Техник мэргэжлийн боловсрол, сургалт

Гол сорилтууд

Залуучуудын боловсролын талаарх төр засгийн бодлого

Залуучуудын эрүүл мэнд

Залуучуудын эрүүл мэндийн талаарх төр засгийн бодлого

Дүгнэлт

### БҮЛЭГ 4. ХӨДӨЛМӨР ЭРХЛЭХ БОЛОМЖИЙГ ӨРГӨЖҮҮЛЭХ НЬ

Удиртгал: Залуучуудыг хөдөлмөр эрхлэлтэд бэлтгэх нь

Залуучууд сургууль төгсөөд ажилд орох хүртэлх шилжилтийн үе

Залуучуудын ажилгүйдэл

Залуучуудын хөдөлмөр эрхлэлт

Залуучуудын ур чадвар ба хөдөлмөр эрхлэх боломж

Залуучуудын хөдөлмөр эрхлэлтийн талаарх төр засгийн бодлого

Дүгнэлт

### БҮЛЭГ 5. ЗАЛУУЧУУДЫГ ЭРХ МЭДЭЛЖҮҮЛЭХ НЬ

Удиртгал: Залуучуудын эрх мэдлийг нэмэгдүүлэх нь

Залуучуудын улс төрийн оролцоо

Залуучуудын нийгмийн оролцоо

Дүгнэлт

### БҮЛЭГ 6. ХҮНИЙ АЮУЛГҮЙ БАЙДЛЫГ БЭХЖҮҮЛЭХ НЬ

Удиртгал: Хүний хөгжлийн төлөө аюулгүй байдлыг

бэхжүүлэх нь

Залуучуудын хүчирхийлэл өртөх эмзэг байдал

Залуучуудыг эрсдэлээс хамгаалах нь

Дүгнэлт

### БҮЛЭГ 7. ЗАЛУУЧУУДЫН ТАЛААРХ БОДЛОГО, ЧИГЛЭЛ

Тулгуур асуудал 1: Чадамжийг хөгжүүлэх нь

Тулгуур асуудал 2: Боломжийг нэмэгдүүлэх нь

Тулгуур асуудал 3: Залуучуудыг эрх мэдэлжүүлэх нь

Тулгуур асуудал 4: Хүний аюулгүй байдлыг бэхжүүлэх нь

Залуучуудын талаарх үндэсний бодлогыг боловсруулах, хэрэгжүүлэхэд тулгарч буй сорилт

### ХАВСРАЛТ

Хавсралт I Хүний хөгжлийн үндэсний зургаа дахь илтгэлийг бэлтгэсэн үйл явц

Хавсралт II Монгол Улсын Хүний хөгжлийн үндэсний илтгэлүүд, тэдгээрийн нөлөө

Хавсралт III Аргачлалын тайлбар

Хавсралт IV ХХИ-ийг тооцох аргачлалд орсон өөрчлөлт

Хавсралт V Олон хэмжүүрт ядуурлын индексийг тооцоход ашигласан үзүүлэлтүүд

Хавсралт VI Боловсролын зарим үзүүлэлтүүд

Хавсралт VII Эрүүл мэндийн зарим үзүүлэлтүүд

Хавсралт VIII Залуучуудын ажилгүйдэл, байршил, боловсрол, хүйсээр

Хавсралт IX Монголын залуучуудын амьдралын чухал үе шатууд

Хавсралт X Монгол Улсын хүн ам

Хавсралт XI Залуучуудын эмзэг байдал, түүнийг шийдвэрлэх арга зам

Хавсралт XII Залуучуудын ажилгүйдэл, байршил, боловсрол, хүйсээр

Хавсралт XIII Залуучуудын амьдралын чухал үе шатууд

Хавсралт XIV Монгол Улсын хүн ам

Хавсралт XV Залуучуудын эмзэг байдал, түүнийг шийдвэрлэх арга зам

Хавсралт XVI Залуучуудын ажилгүйдэл, байршил, боловсрол, хүйсээр

Хавсралт XVII Залуучуудын амьдралын чухал үе шатууд

Хавсралт XVIII Монгол Улсын хүн ам

Хавсралт XIX Залуучуудын эмзэг байдал, түүнийг шийдвэрлэх арга зам

Хавсралт XX Залуучуудын ажилгүйдэл, байршил, боловсрол, хүйсээр

Хавсралт XXI Залуучуудын амьдралын чухал үе шатууд

Хавсралт XXII Монгол Улсын хүн ам

Хавсралт XXIII Залуучуудын эмзэг байдал, түүнийг шийдвэрлэх арга зам

Хавсралт XXIV Залуучуудын ажилгүйдэл, байршил, боловсрол, хүйсээр

Хавсралт XXV Залуучуудын амьдралын чухал үе шатууд

Хавсралт XXVI Монгол Улсын хүн ам

Хавсралт XXVII Залуучуудын эмзэг байдал, түүнийг шийдвэрлэх арга зам

Хавсралт XXVIII Залуучуудын ажилгүйдэл, байршил, боловсрол, хүйсээр

Хавсралт XXIX Залуучуудын амьдралын чухал үе шатууд

Хавсралт XXX Монгол Улсын хүн ам

Хавсралт XXXI Залуучуудын эмзэг байдал, түүнийг шийдвэрлэх арга зам

Хавсралт XXXII Залуучуудын ажилгүйдэл, байршил, боловсрол, хүйсээр



# ТОВЧИЛСОН ҮГ

---

<b>АБС</b>	Азийн барометрийн судалгаа
<b>ЖХИ</b>	Жендерийн хөгжлийн индекс
<b>ДНБ</b>	Дотоодын нийт бүтээгдэхүүн
<b>ЖТББИ</b>	Жендерийн тэгш бус байдлын индекс
<b>ҮНО</b>	Үндэсний нийт орлого
<b>ХХИ</b>	Хүний хөгжлийн индекс
<b>ХДХВ</b>	Хүний дархлал хомсдлын вирус
<b>МХТ</b>	Мэдээлэл, холбооны технологи
<b>ТББТХХИ</b>	Тэгш бус байдлыг тооцсон Хүний хөгжлийн индекс
<b>ЛГБТ</b>	Лесбиян, гей, бисексуал, трансжендер
<b>ОХЯИ</b>	Олон хэмжүүрт ядуурлын индекс
<b>ХБӨ</b>	Халдварт бус өвчин
<b>ХХҮИ</b>	Хүний хөгжлийн үндэсний илтгэл
<b>ТББ</b>	Төрийн бус байгууллага
<b>ҮСХ</b>	Үндэсний статистикийн хороо
<b>ТХЗ</b>	Тогтвортой хөгжлийн зорилт
<b>НҮТС</b>	Нийгмийн үзүүлэлтийн түүвэр судалгаа
<b>БЗДХ</b>	Бэлгийн замаар дамжих халдвар
<b>ТМБС</b>	Техник мэргэжлийн боловсрол, сургалт
<b>НҮБ</b>	Нэгдсэн Үндэстний Байгууллага
<b>НҮБХХ</b>	Нэгдсэн Үндэстний Байгууллагын Хөгжлийн хөтөлбөр
<b>ДЭМБ</b>	Дэлхийн эрүүл мэндийн байгууллага

## Онцлог нэр томъёо

---

<b>Аймаг</b>	Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, бусад улсын мужтай дүйцэх засаг захиргааны нэгж, Монгол Улс 21 аймагтай
<b>Сум</b>	Аймгийн дараах засаг захиргааны нэгж, 2014 оны байдлаар Монгол Улс нийт 330 сумтай
<b>Гэр</b>	Монгол үндэсний сууц
<b>Гэр хороолол</b>	Монгол үндэсний гэрт амьдардаг айлууд олонтой хороолол
<b>УИХ</b>	Монгол Улсын хууль тогтоох дээд байгууллага
<b>Хурал</b>	иргэдийн төлөөллийн байгууллага

## Нэгж

---

% хувь

₮ төгрөг, Монголын үндэсний мөнгөн тэмдэгт

Монгол Улсын энэхүү Хүний хөгжлийн үндэсний зургаа дахь илтгэлийн (ХХҮИ) үндсэн зорилго нь залуучуудын асуудлыг судлах явдал байлаа. Ингэхдээ Монголын залуучуудад бий болсон боломж, сонголт, тэдэнд тулгарч буй сорилтуудад хүний хөгжлийн үзэл хандлагаар дүн шинжилгээ хийлээ. Энэ үзэл хандлага нь хүнийг хөгжлийн төвд тавьж, хүмүүсийн урт удаан, эрүүл саруул, үр бүтээлтэй амьдрах боломж, сонголтыг нэмэгдүүлэхийг чухалчилдаг.

Энэхүү илтгэлийн гол агуулга нь Монголын сайн сайхан ирээдүйг цогцлоон бүтээхэд залуучуудын оруулах хувь нэмрийг тодорхойлоход оршиж байгаа юм. Залуучууд мэдлэгтэйгээр сонголтоо хийх чадамжтай байх, мөн боломж хэр нээлтэй байх нь тэдний хөгжилд оруулах хувь нэмэрт ихээхэн нөлөөлнө. Залуучууд манай дэлхийн ирээдүйг цогцлоогч, манлайлагчид юм.<sup>1</sup> Монголын залуучууд дэлхийн өнцөг булан бүрийн залуусын нэгэн адил өөрчлөлтийг манлайлж, улс орныхоо ирээдүйг цогцлооход чухал үүрэг гүйцэтгэх чадавхитай. Өнөө үеийн залуучууд маань ардчилсан тогтолцоотой нийгэмд амьдралын ихэнх хугацаагаа өнгөрүүлж буй анхны үеийнхэн юм. Энэ нь тэдний төлөв байдал, амьдрал ахуйд онцгой үүрэг гүйцэтгэсэн.

Монгол Улсад 15-34 насны нэг сая гаруй залуучууд аж төрж байна. Тэд 2015 оны байдлаар, нийт хүн амын 34.9 хувийг эзэлж байгаа нь хүн амын хамгийн том бүлэг болж байна. Түүнчлэн тэд хөдөлмөрийн насны хүн амын нилээд хэсгийг бүрдүүлж байна. 2040 он гэхэд тус улсын хүн ам 4 саяд хүрэх хэтийн тооцоогоор ч 15-34 насныхан тэр үед 29 хувийг эзлэх төлөвтэй байна.

Монгол Улсын ДНБ-ний жилийн дундаж өсөлт 2005-2010 онд 6.7 хувьд хүрч, улмаар 2010-2014 онд 12.2 хувь

болтол өсчээ. Гэвч Дэлхийн банкны урьдчилсан тооцоогоор, уул уурхайн бус салбар аажмаар сэргэж байгаа ч уул уурхайн үйлдвэрлэлийн өнөөгийн огцом бууралтаас улбаалан ДНБ-ний өсөлт 2015 онд 2.3 хувь хүртэл саарч, 2016 онд улам буурч 0.8 хувьтай байх төлөвтэй байна.<sup>2</sup> Манай улсын таван хүн тутмын нэг нь ядуурлын түвшингээс доогуур амьжиргаатай байна. Хүн амын амьжиргааны түвшин хот, хөдөөд ихээхэн ялгаатай байна. Гэсэн хэдий ч Монгол Улс нь үндэсний түвшиндээ Хүний хөгжлийн индексээр (0.727) ихээхэн ахиц дэвшил гаргаж дэлхийн хүний хөгжлийн түвшин өндөртэй орнуудын ангилалд шилжив. Өнгөрсөн 20 жилийн хугацаанд Монгол Улс “олон намын ардчилсан тогтолцоотой, эрчимтэй хөгжиж буй эдийн засагтай улс” болж, одоо “ашигт малтмалын үлэмж нөөцөө ашигласанаар томоохон өөрчлөлт хийх цаг мөчтэй” тулж ирээд байна.<sup>3</sup>

Энэхүү Хүний хөгжлийн үндэсний илтгэлийг боловсруулахдаа дараах гол асуудалд анхаарал хандууллаа. Үүнд, Монголын залуучууд эдийн засгийн өсөлт, нийгмийн хөгжил, дэвшлийн үр шим, боломжийг хэр зэрэг хүртэж байна вэ? “Өөрсдийн эрхэмлэдэг, эрхэмлэх үндэстэй тийм үр дүнд хүрэх” сонголтыг хийхэд нь тэдэнд ямар сорилтууд тулгарч байна вэ?<sup>4</sup> Эдгээр сорилтыг шийдвэрлэх ямар бодлогууд байна вэ? Залуучуудыг улс орныхоо хөгжил дэвшилд оролцуулахад хамтрагчид, түншүүд ямар арга хэмжээг авч болох вэ? Эдгээр асуудлыг судлахдаа залуучуудын чадамжийг хөгжүүлэх, хөдөлмөр эрхлэлтийн боломжийг өргөжүүлэх, залуучуудыг эрх мэдэлжүүлэх, хүний аюулгүй байдлыг нь бэхжүүлэх зэрэг хүний хөгжлийн дөрвөн гол тулгуур зарчмын ойлголтыг дүн шинжилгээнийхээ гол хүрээ болгож ажилласан болно.

## **Залуучуудын чадамжийг хөгжүүлэх нь**

Хүмүүст мэдлэг боловсрол эзэмших боломжийг нэмэгдүүлэх, урт удаан, эрүүл саруул амьдрах нөхцөлийг бүрдүүлэх нь хүний хөгжлийн хоёр чухал хэмжүүр юм.

## **Залуучуудын боловсрол**

**Боловсролын бүх шатанд залуучуудын бүтээлч сэтгэлгээг хөгжүүлэх, хөдөлмөрийн зах зээлийн эрэлт хэрэгцээтэй нийцэхүйц боловсрол эзэмшүүлэх нь тэднийг үр өгөөжтэй, сэтгэл хангалуун амьдралд бэлтгэх чухал нөхцөл болно.**

Боловсрол эзэмшсэнээр хүмүүст ажил хөдөлмөр эрхлэх боломж нэмэгдэхийн сацуу эрүүл саруул, эрх мэдэлтэй байх, нийгмийн амьдралд илүү идэвхтэй оролцох зэрэг хүний хөгжлийн бусад олон талын ашиг тусыг хүртэх боломж нээгдэнэ. Монгол Улс иргэн бүртээ, ялангуяа залуучуудаа боловсрол эзэмшүүлэх талаар ихээхэн амжилтанд хүрсэн.

Бүх шатны сургуулийн элсэлт 2000 оноос хойш илүү нэмэгдсэн нь Хүний хөгжлийн индексийн өсөлтөд эерэгээр нөлөөлснийг илтгэлд тэмдэглэж байна. Дэлхийн Хүний хөгжлийн илтгэлд тооцоолсноор 2014 онд сургуульд орж буй хүүхэд 14.6 жил сургуульд суралцах боломжтой байгаа нь хүний хөгжлийн түвшин өндөртэй нилээд хэдэн улсынхаас дээгүүр үзүүдэлт юм.

Бүх хүүхдийг 9 дүгээр ангийн боловсрол заавал эзэмшүүлэх асуудал үндсэндээ бүрэн хэрэгжиж байна. 2014/2015 оны хичээлийн жилийн байдлаар, бага сургуулийн элсэлтийн хамралт 99.1 хувь, дунд сургуулийн элсэлтийн хамралт 96.1 хувьтай байна. 15-аас 19 насны залуучуудын 80 орчим хувь нь сургуульд суралцаж байна. Хөдөөд сургуульд хамрагдалт хотынхоос доогуур хэвээр байгаа ч хот, хөдөөгийн ялгаа багасч байна. Төдийлөн түгээмэл байдаггүй суралцагчдын жендэрийн

урвуу ялгаа ч (хөвгүүд сургуульд охидоос цөөн хамрагдах) мөн багасч байгаа бөгөөд бага дунд сургуулийн эмэгтэй, эрэгтэй сурагчдын харьцаа бараг тэнцүү болжээ.

2000 оноос хойш дээд болон техник мэргэжлийн боловсрол сургалтын эрэлт хэрэгцээ, түүнчлэн элсэлт огцом нэмэгдсэн байна. Хүн ам, орон сууцны тооллогын мэдээллээс үзэхэд 2000-2010 онд дээд боловсролтой эмэгтэй, эрэгтэй залуучуудын эзлэх хувь бараг гурав дахин өсчээ.

Бүх шатны сургуульд хамрагдалт ийнхүү нэмэгдсэн хэдий ч боловсрол эзэмших боломж хүн бүрт тэгш бус байна. Хөгжлийн бэрхшээлтэй залуучуудын боловсрол эзэмших боломж хязгаарлагдмал хэвээр, тухайлбал, ерөнхий боловсролын сургуулийн насны хөгжлийн бэрхшээлтэй хүүхдүүдийн ердөө 66.2 хувь нь л сургуульд суралцаж байна. Төрөлхийн хөгжлийн бэрхшээлтэй залуучуудын бараг тал хувь нь бичиг үсэг тайлагдаагүй эсвэл боловсролгүй байна. Багш сургагчид зохих түвшинд бэлтгэгдээгүй, шаардлагатай дэд бүтэц сургуулиудаа байхгүй зэргээс эдгээр залуучууд ихээхэн саад бэрхшээлтэй тулгарч байна. Ийм байдал нь хөгжлийн бэрхшээлтэй хүмүүс нийгэмд ялгаварлагдах явдлыг даамжруулж болох юм. Түүнчлэн өрхийн амьжиргааны түвшнээс хамааран залуучууд дээд боловсрол эзэмшихэд ялгаатай байдал үүсч байна. Мөн дийлэнх их, дээд сургуулиуд байрладаг нийслэл Улаанбаатар хотын байр орон сууцны үнэ болон амьжиргааны өртөг эрчимтэй өсч байгаагаас хөдөөгийн залуучууд дээд боловсрол эзэмшихэд улам бүр хүндээр тусч байна.

Залуучуудын ур чадварыг дээшлүүлж, тэднийг үр бүтээлтэй амьдралд бэлтгэх өндөр чанартай боловсрол эзэмших нөхцөл боломж хэр байгааг судлахад тэдэнд олон сорилт бэрхшээл тулгарч байна. Бүх шатны боловсролын чанар хангалтгүй байгаа нь тулгамдсан асуудлын нэг болоод байна. Энэ нь

боловсролын өгөөжийг бууруулж, залуучууд чадамжаа хөгжүүлэх боломжийг хязгаарлан, тэдний цаашдын хөдөлмөр эрхлэлтийн төлөвт сөргөөр нөлөөлж байна. Хөдөө орон нутгийн дунд сургуулийн сурагчдад Интернет болон бусад сурах боломж хязгаарлагдмал, мэргэжлийн багш, сургалтын хэрэгсэл дутагдалтай зэрэг бэрхшээл тулгарч байна. Залуучууд дээд болон техник мэргэжлийн сургуульд дэвшин суралцах үед ч сургалтын чанарын асуудал гарсаар байна. Сургалтын зарим хөтөлбөрүүд хоцрогдсон, чанартай сурах бичгүүд ховор байна. Хичээлийн хөтөлбөрүүд нь ажил олгогчдоос тавих шаардлагад нийцэхгүй, дадлагажих, ажилд орох боломж төгсөгчдөд хязгаарлагдмал байна. Хөдөлмөрийн зах зээлд шаардлагатай мэдлэг ур чадварыг залуучуудад олгох өнөөгийн дээд боловсролын өгөөж сул байна. Энэ нь дээд болон техник мэргэжлийн боловсролтой залуучуудын ажилгүйдлийн түвшин дунд болон бага боловсролтой залуучуудынхаас өндөр байгаагаар илэрч байна.

Боловсролын чанарыг сайжруулах дээрх хэрэгцээ шаардлагын үүднээс сургалтын жил, бүтцийг шинэчлэн өөрчлөх, сургалтын хөтөлбөрийг боловсронгуй болгох, боловсролын шинэ стандартыг боловсруулан мөрдөх, магадлан итгэмжлэлийн тогтолцоог бэхжүүлэх, багш нарын сургалтын цар хүрээг нэмэгдүүлэх зэрэг боловсролын цогц шинэчлэл, шинэлэг санаачилгуудыг засгийн газраас хэрэгжүүлж байна. Түүнчлэн залуучуудын тасралтгүй суралцах боломж, тэдэнд дүйцүүлэх сургалтад хамрагдах боломжийг өргөжүүлэхэд тодорхой ахиц гарч байна. Тухайлбал, мэдээлэл, холбооны технологийн хөгжил, түүний хүртээмж эрс дээшилсэн нь залуучуудад мэдлэг, мэдээлэл олж авах, дэлхий ертөнцтэй холбогдох шинэ арга хэрэгсэл болж байна.

Монгол Улсын Засгийн газар 2014 онд ДНБ-нийхээ 5.3 хувь, 2015 онд 4.3 хувийг

боловсролын салбарт зарцуулжээ. ДНБ-ний өсөлтийг тооцвол боловсролын бодит зардал 2002-2012 онд 59 хувиар өсчээ. Гэвч багш нарын мэргэжлийн ур чадварыг хөгжүүлэх, сургуулиудын лабораториудыг сайжруулах, шинэ сурах бичиг болон сургалтын бусад хэрэгсэлээр хангахад чиглэгдсэн шинэчлэлийн хөтөлбөрийг амжилттай хэрэгжүүлэхэд төрийн санхүүжилт дангаар хүрэлцэхгүй байна.

Залуучуудын чадамжийг эрчимтэй хөгжүүлэхийн тулд өндөр чанартай боловсрол эзэмших тэгш боломжийг бүрдүүлэх, ялангуяа хөгжлийн бэрхшээлтэй болон бага орлоготой өрхийн залуучуудын хамралтыг нэмэгдүүлэх зэргээр тулгамдсан асуудлуудыг нэн яаралтай шийдвэрлэх арга хэмжээг засгийн газар, бусад холбогдох талууд авах шаардлагатай байна.

### **Залуучуудын эрүүл мэнд**

**Амьдралын эрүүл дадал хэв маягийг хэвшүүлэх нь эрүүл мэндийн эрсдлийг бууруулах, сэргийлэх боломжтой аливаа өвчинд өртөхгүй байж улмаар урт удаан, эрүүл сарууд амьдрах нөхцөлийг бүрдүүлэхэд чухал ач холбогдолтой.**

Эрүүл байх нь залуу хүмүүсийн чадамжийг хөгжүүлэхэд нэн чухал. Эрүүл сарууд, сайн сайхан амьдрах нь залуусын амьдралын чанар болон тэдний бүтээмжид шууд нөлөөлөөд зогсохгүй, улмаар нийгэм, улс орны хөгжлийн төлөв, түвшинг тодорхойлдог. Монголын залуучуудын дунд эрсдэлт зан үйл түгээмэл тохиолдож байгаа нь тэдний ирээдүйн чадамжийг боогдуулж, сэргийлэх боломжтой аливаа өвчин, эндэгдлээс сэргийлэх, эрүүл, үр бүтээлтэй амьдрах нөхцөлийг хязгаарлаж болох талтай.

15-34 насны залуучуудын дундаж наслалт удаан нэмэгдэж байгаа нь анхаарал татаж байна. 1990 оноос хойш энэ насны бүлгийн эмэгтэйчүүдийн наслалт 2-3 жилээр нэмэгдсэн байхад

залуу эрэгтэйчүүдийн дундаж наслалт тухайн насны бүх бүлэгт буурчээ. Тухайлбал, эрэгтэйчүүд зам, тээврийн осолд эмэгтэйчүүдээс 4 дахин илүү өртөж байна.

Залуучуудын дундаж наслалт нэмэгдэх явц ийнхүү удаан байгаагийн болон насанд хүрэгсэдийн нас баралтын суурь шалтгаан нь архи согтууруулах ундаа хэрэглэх, тамхи татах, зохисгүй хооллох, хөдөлгөөний хомсдол, залуучууд, өсвөр үеийнхний таргалаалт зэрэг эрсдэлт зан үйл түгээмэл байгаатай холбоотой байж болохыг судлаачид тэмдэглэж байна. Монголд залуучууд жимс, ногоо тун бага хэрэглэдэг, давсны хэрэглээ олон улсын хүлээн зөвшөөрөгдсөн хэмжээнээс даруй хоёр дахин өндөр байгааг судалгааны дүн харуулж байна. Жингийн илүүдэлтэй, таргалаалттай залуучуудын хувь өндөр байна. Залуучуудын бараг гуравны нэг нь тамхи татдаг, архи согтууруулах ундааны хэрэглээ ч их байна.

Халдварт бус өвчнүүд (ХБӨ) эдүгээ манай улсын эрүүл мэндийн томоохон эрсдэл болж, хүн амын нас баралтын шалтгааны 80 орчим хувийг эзэлж байна. Бүх насны залуучуудын дотор осол гэмтэл, хордлого, гадны бусад нөлөөллөөр нас барах явдал эндэгдэлийн дийлэнх хувийг эзэлж байгаа бөгөөд 2010 оноос хойш энэ үзүүлэлт өсөх төлөвтэй байна. Ихэнх төрлийн халдварт бус өвчнүүдээс сэргийлэх, эмчлэх боломжтой атал тэдгээрийн дийлэнх нь өсвөр болон залуу насанд үүссэн байдаг. Зохих бодлого, дэмжлэгтэй орчин бүрэлсэн нөхцөлд өсвөр үеийнхэн, залуучууд эрүүл амьдралын дадал, хэв маягийг мөрдөх боломжтой, тэдэнд ийм чадамж бий.

Залуучуудыг эрүүл мэндийн эрсдэлд хүргэж буй тогтолцооны хүчин зүйлүүдийн нөлөөг судласнаар, эрүүл амьдралын хэв маягийг хэвшүүлэх дэмжлэгт орчныг бий болгох шаардлагатайг тэмдэглэж байна. Манай улсад тамхи, согтууруулах ундааны үнэ харьцангуй хямд,

тэдгээрийн хэрэглээг хязгаарлах хууль тогтоомжийн хэрэгжилт сул, эрүүл бус хүнсний бүтээгдэхүүнийг зах зээлд өргөнөөр сурталчилдаг, жимсний үнэ өндөр, биеийн тамир спорт, чөлөөт цагаа өнгөрүүлэх газрууд цөөн зэрэг тогтолцооны хүчин зүйлүүд нь залуучуудад эрүүл амьдралын хэв маягийг хэвшүүлэхэд саад учруулж байна. Иймд тамхины хэрэглээнд хяналт тавих тухай хууль батлагдсан, замын хөдөлгөөний дүрмийг чангатгасан зэрэг сайшаалтай алхмуудаас гадна залуучуудын эрсдэлтэй, эрүүл бус зан үйлд нөлөөлж байгаа тогтолцооны хүчин зүйлүүдийг шийдвэрлэхэд Засгийн газраас илүү дорвитой бодлого хэрэгжүүлэх шаардлагатай байна.

Өсвөр насны охидын төрөлтийн түвшин нэмэгдэж байгаа нь тус улсын жендэрийн тэгш бус байдлын индекст сөргөөр нөлөөлжээ. Монголын өсвөр насны охидын төрөлтийн түвшин Ази, Номхон далайн бүс нутгийн дундаж үзүүлэлтээс дээгүүр байгаа бөгөөд 2003 онд 15-19 насны 1000 охид тутамд 19 төрөлт ногдож байсан бол энэ нь 2013 онд 29 болтлоо өсчээ. Гэр бүл төлөвлөлтийн хангагдаагүй хэрэгцээ энэ насны бүлгийн охид, эмэгтэйчүүдэд хамгийн өндөр буюу 36.4 хувь байна. Бэлгийн эрсдэлтэй зан үйл түгээмэл байгаагаас үүдэн бэлгийн замаар дамжих халдвар нийгмийн эрүүл мэндийн тулгамдсан асуудал болж байна. Хүний дархлал хомсдлын вирусийн (ХДХВ) бүртгэгдсэн халдварын дотор 15-24 насны залуучууд 20 орчим хувийг эзэлж байна. Энэ нь зонхилох хувь бус хэдий ч бэлгийн замаар дамжих бусад халдварын дийлэнхи хэсэг нь залуучуудад тохиолдож байгаа нь (жилд бүртгэгдсэн нийт халдварын 40-50 хувь) ХДХВ-ийн халдварт тэд илүү эрсдэлтэй болохыг харуулж байна. 2015 оны тайланд ХДХВ/ДОХ-ын халдвар авсан хүмүүсийн 41.2 хувь нь 30 хүртэлх насны залуучууд байсны 54 хувь нь эмэгтэй, 43 хувь нь эрэгтэйчүүд байна (үлдсэн 3 хувь нь хүйсээ мэдээлээгүй).<sup>5</sup> Иймд залууст ээлтэй эрүүл мэндийн тусламж үйлчилгээ, бэлгийн эрүүл

мэндийн чанартай боловсрол зайлшгүй шаардлагатай байна.

Залуу хүмүүс эрүүл мэндийн тусламж үйлчилгээ авах боломж байгаа хэдий ч хүссэн хэрэгцээнд нь нийцсэн үйлчилгээ дутмаг байгаагаас тэдний эмнэлэг, эрүүл мэндийн төвд хандах нь цөөн байна. Өнөөдөр улсын хэмжээнд залууст ээлтэй өсвөр үеийн 25 эрүүл мэндийн төв ажиллаж байгаа бөгөөд цаашид ийм төвүүдийн үйлчилгээг өргөжүүлэх талаар бодитой арга хэмжээ авах шаардлагатай.

Эрүүл мэндийн тусламж үйлчилгээний зардал инфляцийн түвшинг тооцсоноор 2012 оны байдлаар 8.8 хувь өссөн хэдий ч 2002-2012 онд эрүүл мэндийн үйлчилгээний төсвийн зардалын ДНБ-нд эзлэх хувь 4.6 хувиас 3.0 хувь болтол буурсан байна. Түүнчлэн эрүүл амьдрахад сөргөөр нөлөөлж буй нийгэм, байгаль орчин болон зан үйлтэй холбоотой асуудлуудыг шийдвэрлэхэд эрүүл мэндийн салбарын санхүүжилт дангаараа хангалтгүй.

Иймд нийгмийн эрүүл мэндийн санхүүжилтийг тухайн салбарын санхүүжилтээс илүү өргөн хүрээнд авч үзэх хэрэгтэй байна. Өсвөр үе, залуучуудад эрүүл амьдрах зан үйлийг төлөвшүүлэх нь насанд хүрсэн хойно нь асуудлыг шийдвэрлэхээс нийгмийн болоод эдийн засгийн хувьд илүү үр дүнтэй. Иймд амьдралын эрүүл хэв маягийг түгээн дэлгэрүүлэх, залуучуудын осол, гэмтлийн эрсдлийг бууруулахад чиглэсэн төр засгийн үр дүнтэй бодлого, эрүүл мэндийг дэмжих хөтөлбөрүүдийг хэрэгжүүлэх шаардлагатай байна.

### **Хөдөлмөр эрхлэх боломжийг өргөжүүлэх нь**

**Шинэлэг, үр бүтээлтэй, сэтгэл ханамжтай, хангалттай цалин хөлстэй хөдөлмөр эрхлэх боломжийг бий болгох нь залуучууд амьдралаа авч явах, эдийн засгийн хувьд баталгаатай болох улмаар тэдний чадавхи, бүтээлч сэтгэлгээг нь хөгжүүлэх нөхцлийг бүрдүүлнэ.**

Хөдөлмөр эрхлэлт нь хүний амьдралын эрхэм чухал зүйл болох эрх чөлөөг хангах нэг чухал хэрэгсэл юм. Ажилтай болох нь залуусын хувьд нас биед хүрч амьдралын гараагаа эхлэх чухал алхам болдог. Тогтвортой ажил эрхэлж, эдийн засгийн шийдвэр гарган амьдралынхаа төлөө хариуцлага хүлээдэг болсноор залуучууд санхүүгийн хувьд хараат бус болж, хүсэл мөрөөдлөө биелүүлэх боломжтой болно.

Боловсрол эзэмшээд цаашид тогтвортой ажил хайх хугацаандаа залуучууд сургуулиас ажилд шилжих үе шатыг туулдаг. Манай улсын 15-18 настнуудын олонх нь дунд сургуульд сурч байгаа бөгөөд 25-34 насны залуучуудын талаас илүү нь тогтвортой ажил хайсаар, 40 гаруй хувь нь сургуулиас ажилд шилжиж амжаагүй байдалтай байна.

Хөдөөгийн залуучуудтай харьцуулахад хотын залуучууд дээрх шилжилтийн үеийг хожуу эхэлж (ихэвчлэн 21 наснаас хойш) байна. Энэ нь тэдний дээд боловсрол эзэмших сонирхол, нөгөө талаар залуучуудын олж авсан ур чадвар хөдөлмөрийн зах зээлийн хэрэгцээ, ажил олгогчдын шаардлагыг хангадаггүй, хотод тохирох ажлын байр дутмаг байгаа зэргээс тэд анхныхаа тогтвортой ажилд ортолоо 2.9 жил хүртэл хугацаа зарцуулж байгаатай мөн холбоотой.

Хөдөлмөрийн зах зээлд орж байгаа залуучуудын хувь 25-34 насны бүлэгт нэмэгддэг. Эмэгтэйчүүд эрэгтэйчүүдээс илүү олон тоогоор дээд боловсрол эзэмшиж байгаа хэдий ч энэ насны бүлэгт хөдөлмөр эрхэлж байгаа залуучуудын дотор эрэгтэйчүүд нь давамгайлж байна. Энэ нь дээд боловсрол тэр бүр шаардахгүй ажлын байр илүү олон байгаа, аль эсвэл эмэгтэйчүүд гэрийн ажил, бусад цалин хөлсгүй ажил үүргээсээ болоод хөдөлмөрийн зах зээлд орохоо хойш тавьдагтай холбоотой байж болох юм.

Илтгэлд Монгол Улсын эдийн засгийн өсөлт хүний хөгжлийг түргэсгэхэд хэрхэн нөлөөлж байгаа, ялангуяа

залуучуудад тогтвортой, бүтээмжтэй ажил эрхэлж, эдийн засгийн хувьд баталгаатай болох боломжийг хэр олгож байгаа талаар судаллаа. Эдийн засгийн өсөлт ба хүний хөгжлийн индексийн өөрчлөлт нь харилцан уялдаатай байдгийг, эдийн засгийн өсөлт нь хүний хөгжилд мэдэгдэхүйц ахиц дэвшил гарах нөхцөл бүрдүүлдгийг Монголын өнгөрсөн жилүүдийн түүх харуулж байна. 1990 оноос хойших хугацаанд гарсан хүний хөгжлийн индексийн өсөлтийн хандлагаас харахад тус улсын эдийн засгийн жилийн дундаж өсөлт 7.0 орчим хувьтай байсан 2000-2014 онд хүний хөгжлийн индекс хамгийн хурдацтай өсчээ.

Сүүлийн үеийн эдийн засгийн өсөлттэй холбоотойгоор хөдөлмөрийн зах зээлд хэд хэдэн эерэг хандлага бий болсон боловч залуучуудыг зохистой, бүтээмжтэй ажлын байраар хангахад дорвитой ахиц гарсангүй. Сүүлийн хоёр, гурван жилд уул уурхайн салбарын өсөлт саарснаас уул уурхай болон түүнийг дагалдсан салбаруудад залуучууд ажлын байртай болох боломж бүр ч хязгаарлагджээ.

Залуучуудын ажилгүйдлийн түвшин 15-34 насны бүлэгт 2013 онд 10.8 хувьтай, 20-24 насны бүлэгт хамгийн өндөр буюу 17.0 хувьтай байсан нь улсын хэмжээний ажилгүйдлийн түвшингээс бараг хоёр дахин илүү байв. Аймаг, сумдын төвүүдэд залуучуудын ажилгүйдлийн түвшин 17.0-19.0 хувь байгаа нь улсын дундажаас нилээд өндөр үзүүлэлт бөгөөд аймаг, суманд залуучуудад ажил эрхлэх боломж хомс байгаагийн илрэл юм.

Тохирох ажлаа хайж байгаа залуучуудын 63 хувь нь нэг жил гаруй, 40 гаруй хувь нь гурван жил гаруй хугацаанд ажил хайж байгаа нь залуучууд удаан хугацааны ажилгүйдэл болон эдийн засгийн баталгаагүй байдалд орж илүү эмзэг эрсдэлтэй болж байна. Энэ нөхцөлд залуучууд эзэмшсэн мэдлэг ур чадвараа алдах, санхүүгийн хувьд доройтох, эрүүл мэнд болон бусад эрсдэлд илүү өртөх, улмаар ажил хайх урам зориг нь

мохох зэрэг таагүй үр дагаварт хүргэж болзошгүй. Цалин бага, хөдөлмөрийн зах зээлийн эрэлт бага, мэргэжлийн ур чадвар, дадлага туршлага дутмаг, ажлын байрны талаарх мэдээлэл хомс зэрэг нь ажилгүй залуучууд ажил олж чадахгүй байгаа гол шалтгаан болж байна.

Боловсролтой залуучууд ажилгүйдээл өртөх эрсдэл өндөр байгаа нь эзэмшсэн боловсролынхоо үр өгөөжийг хүртэж чадахгүйд хүргэж байна. Дээд, техник мэргэжлийн боловсролтой залуучуудын ажилгүйдлийн түвшин боловсрол багатай хүмүүсийнхээс өндөр байгаа нь үүнийг илтгэж байна.

Өсөлтөд үзүүлэх хөдөлмөр эрхлэлтийн мэдрэмж 2000 оноос хойш олон салбарт сул байна. Уул уурхайн болон эдийн засгийн ерөнхий өсөлтийг даган түүхий эдийн үнэ нэмэгдсэн хэдий ч хөдөлмөр эрхлэлтийн өсөлтөд дорвитой ахиц гарсангүй. Энэ нь өсөлтийн үр шимийг залуучуудын бүтээмжтэй хөдөлмөр эрхлэлт рүү чиглүүлэхэд тулгарч буй томоохон сорилтуудын нэг болж байна.

Залуучуудын хөдөлмөр эрхлэлтийн түвшин тэдний оршин суугаа газар нутгийн байршлаас шалтгаалан нилээд ялгаатай байна. Тухайлбал, 2010 оны байдлаар хотын залуучуудын 39.2 хувь, хөдөөгийн залуучуудын 22.2 нь хөдөлмөр эрхэлж байв. 2000 оноос үйлчилгээний салбарт ажиллагсад 40 гаруй хувиар нэмэгдэж залуучууд олноор ажиллах болжээ. Гэхдээ эдгээр ажлын байрны дийлэнх нь түр, байнгын бус байгаа учир тэдэнд тогтвортой ажлын баталгаа болж чадахгүй байна. Түүнчлэн анх ажилд орсон 15-34 насны залуучуудын 30 гаруй хувь нь албан бус салбарт ажиллаж байна. Сүүлийн жилүүдэд барилгын салбар эрчимтэй хөгжсөн хэдий ч тус салбарт ажиллах залуучуудын хувь тун бага, 6-гаас 8 хувиар л өсчээ. Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн 80 орчим хувь нь эдийн засгийн идэвхигүй байдалтай байна (хөгжлийн бэрхшээлтэй залуучуудын хөдөлмөр эрхлэлтийн талаар бодитой тоо мэдээлэл хомс байна).

Залуу эмэгтэйчүүд хөдөлмөрийн зах зээлд эхэлж болон эргэн ороход илүү саад бэрхшээлтэй тулгарч байна. Залуу эмэгтэйчүүдийн ажилгүйдлийн түвшин залуу эрэгтэйчүүдийнхээс өндөр байгаа бөгөөд энэ нь жилээс жилд өсөх хандлагатай байна. Эмэгтэйчүүд боловсрол (80.6 хувь), эрүүл мэнд, нийгмийн халамж (79.4 хувь), нийгмийн ухаан, бизнес болон хууль (64.3 хувь) зэрэг салбарт голдуу ажиллаж байгаа нь ажил мэргэжлийн хүйсийн зааглал илт байгааг харуулж байна. Инженер, үйлдвэрлэл, барилгын мэргэжлээр төгсөгчдийн дөнгөж 30.0 хувийг эмэгтэйчүүд эзэлж байгаа нь шинжлэх ухаан, техник технологийн салбарт эмэгтэйчүүдийн төлөөлөл бага байгаагийн илрэл юм. Залуу эмэгтэйчүүдийн цалин хөлс залуу эрэгтэйчүүдийнхээс 1.4 дахин бага, харин цалин хөлсгүй ажилд эмэгтэйчүүд зонхилж байна. Тухайлбал, 2011 оны байдлаар 25-29 насны эмэгтэйчүүдийн 17 хувь нь гэрийн ажилтай гэж мэдээлсэн байхад энэ насны бүлгийн залуу эрчүүдийн зөвхөн нэг хувь ийм ажил хийдэг гэжээ. Ийнхүү залуучуудын аунд хөдөлмөрийн зах зээл дахь жендэрийн ялгаатай байдал илт байгаа нь жендэрийн мэдрэмжтэй хөдөлмөрийн зах зээлийн бодлого шаардлагатайг харуулж байна.

Монгол Улсын Засгийн газраас ажлын байр бий болгох асуудлыг эдийн засгийн болон хөдөлмөр эрхлэлтийн бодлого, хөтөлбөрийн нэг гол чиглэл болгон макро эдийн засгийн бодлогыг хөдөлмөрийн зах зээлийн бодлоготой уялдуулах, хүнд, хөнгөн үйлдвэрлэлийг хөгжүүлэхэд хөрөнгө оруулах, залуучууд, хөгжлийн бэрхшээлтэй хүмүүс, шилжин суурьшигчид, оюутнуудын хөдөлмөр эрхлэлтийг дэмжих хөтөлбөрүүдийг өргөжүүлэх, ажилгүй хүмүүсийн сургалт, давтан сургалтыг нэмэгдүүлэх зэрэг олон арга хэмжээ авч байна. Гэсэн хэдий ч залуучуудын тогтвортой, бүтээмжтэй хөдөлмөр эрхлэлтийг дэмжих илүү өргөн цар хүрээтэй, илүү эрчимтэй хөтөлбөрүүдийг хэрэгжүүлэхэд ихээхэн

хүчин чармайлт гаргах шаардлагатай байна.

Сургуулиас ажилд шилжих явцдаа залуучууд, ялангуяа нэн ядуу өрхийн сургууль дөнгөж төгссөн залуус төр засгаас ямар нэгэн санхүүгийн тэтгэлэг авдаггүй учир тэд зөвхөн эцэг, эхийн гарыг харахад хүрч байна. Иймд нэн ядуу өрхийн сургууль шинээр төгссөн залуучуудад зохих ажил олголт нь төр засгаас нийгмийн зорилтот хөтөлбөрт хамруулан сургууль төгссөний дараах нэг жилийн хугацаанд тэтгэлэг олгодог байх талаар судлаж үзэхийг зөвлөж байна.

2015 оны 12 дугаар сарын 15-ны өдөр Улаанбаатар хотноо танилцуулсан “Хүний хөгжлийн төлөөх АЖИЛ” сэдэвт Дэлхийн Хүний хөгжлийн илтгэлд ажил хөдөлмөрийг хөхиүлэн дэмжих замаар хүний хөгжлийг түргэсгэх бодлогын шинэлэг хувилбаруудыг санал болгосон. “Ажил нь ажлын байрнаас өргөн ойлголт, хүн төрөлхтний дэвшил, хүний хөгжлийг түргэсгэгч” хэмээн илтгэлд тэмдэглэжээ.<sup>6</sup> Дэлхийн илтгэлд зөвлөснөөр Монгол Улсын энэ удаагийн Хүний хөгжлийн үндэсний илтгэлээр төр засаг, бусад олон талуудад хандан залуучуудынхаа хөдөлмөр эрхлэх боломжийг нэмэгдүүлэх бүх талын арга хэмжээг хойшлуулалгүй авахыг уриалж байна.

### **Залуучуудыг эрх мэдэлжүүлэх нь**

**Улс төрд залуучуудын итгэл алдарч байгаа нь засаглалыг улам сайжруулах, залуучуудад чиглэсэн төр засгийн зохистой бодлогыг боловсруулахад болон хөгжлийн үйл явцад тэдний оролцоог хангахыг шаардаж буй бодлого боловсруулагчид, шийдвэр гаргагчдад хандсан сануулга хэмээн ойлгох шаардлагатай байна.**

Хүмүүсийг эрх мэдэлжүүлснээр тэднийг хөгжилд болон өөрсдийнх нь амьдралтай холбоотой аливаа шийдвэрт



нөлөөлөх эрх чөлөөг эдлэх боломжийг олгоно. Залуучууд бол хувь хүний өөрийн гэсэн үзэл бодол нь төлөвшиж, илүү хариуцлагатай сонголт хийх, нийгэмд танигдаж харилцаанд орж эхлэх, улс төрийн үйл ажиллагаанд оролцох, таалагдсан үзэл санаагаа дэмжих, хамт олон бүрдүүлэх, иргэний нийгмийн байгууллага, бүлэгт гишүүнээр элсэх, хүсэл шаардлагаа илэрхийлэх, өөрийн үйлдэлдээ хяналт тавьж сурах чухал үе юм. Ингэснээр залуучуудад эрх мэдлийн мэдрэмж бий болоход тус дөхөм болдог. Гэхдээ эрх мэдэлжүүлэх үйл явц шууд бий болдоггүй, хүмүүсийн улс төрийн болон нийгмийн оролцооны хэлбэрээр илэрч байдаг.

Сүүлийн арваад жилд манай залуучуудын сонгуулийн ирц буурчээ. Энэ нь ардчиллын институтууд залуучуудын асуудлыг шийдвэрлэх, ашиг сонирхлыг нь хамгаалах тэдний оролцоог дэмжихэд хангалттай анхаарал тавихгүй байгаа, тэдний үзэл бодол, дуу хоолой улс төрийн үйл ажиллагаанд зохистой хэмжээнд тусгалаа олохгүй байгаа зэргээс шалтгаалж байна.

2010-2012 онд хийсэн Азийн Барометрийн Судалгаагаар (АВС) Монголын залуучууд эрх чөлөөг ардчиллын хамгийн чухал шинж гэж тодорхойлжээ. Гэсэн хэдий ч залуучуудын нилээд хэсэг нь буюу 42 хувь нь хүчирхэг удирдагчийн, эсвэл нэг намын засаглал зэрэг ардчилсан бус хувилбарыг дэмжиж байгаа нь ажиглагдлаа.

Монголын залуучуудын улс төрийн институтууд итгэх итгэл байгууллага бүрийн хувьд ялгаатай байна. Зэвсэгт хүчин, телевиз, Ерөнхийлөгч, цагдаад итгэх тэдний итгэл өндөр байна. Дээд боловсролтой болон хотын залуучууд боловсрол багатай болон хөдөөгийн үе тэнгийнхнээсээ төр засгийн үйл ажиллагаанд илүү шүүмжлэлтэй хандаж байна. Монголын залуучууд улс төрийн амьдралаас ерөнхийдөө холдоогүй, сонирхсоор байна. Тэдний гуравны нэгээс илүү нь улс төрийн талаарх мэдээг байнга анхааралтай сонсдог бол

өсвөр үеийнхэн улс төрийг хамгийн бага сонирхож байна.

Эрх мэдлийг илэрхийлэх нэг чухал үзүүлэлт бол тэдний улс төрийн оролцоо төр засгийн үйл ажиллагаанд хэр зэрэг нөлөө үзүүлж байгаа талаарх залуучуудын мэдрэмж юм. Монголын залуучуудын 60 орчим хувь нь улс төрийг бохир, шударга бус байдал чадварлаг хүмүүсийг улс төрөөс зай барихад хүргэж байна гэж үздэг ажээ. Судалгаанд оролцогчдын тал хувь нь төр, засгийн удирдагчид зөв бодлого хэрэгжүүлнэ гэдэгт итгэдэггүй гэсэн нь улс төрийн үйл ажиллагаанд тэд сэтгэл дундуур байгааг харуулж байна. Энэ нь ардчилсан хувьсгалыг үндсэндээ залуучууд манлайлж байсан 1990-ээд оны үеэс эрс ялгаатай байгаа юм.

Залуучуудын иргэний болон нийгмийн оролцоо нь тэдний хөгжлийн нэгэн эерэг илэрхийлэл юм. Ингэснээр тэдэнд эрх үүргээ мэдрэх, иргэний үүргээ биелүүлэх, амьдрах ур ухаанаа хөгжүүлэх, өөр хоорондоо харилцах, хөдөлмөр эрхлэх, сурсан мэдсэнийхээ үр шимийг хүртэх боломж бий болдог. Монголын залуучууд иргэний нийгмийн байгууллагууд, залуучуудын хөтөлбөрүүд, залуучуудын гаргасан санаачилга, хамтын болон бие даасан сайн дурын үйл ажиллагаагаар дамжуулан нийгмийн амьдралын олон салбарт идэвхтэй оролцож байна. Сайн дурын үйлс залуучуудын дунд улам өргөжиж, олон залуучууд сайн дурын үйл ажиллагааг нийгэмд эерэг өөрчлөлт авчиргах арга зам гэж үздэг болов.

Технологийн шинэ шинэ арга хэлбэрүүд залуучууд мэдээлэл авах, аливаа хөдөлгөөн, сүлжээнд нэгдэх, үзэл бодлоо хуваалцах зэрэгт асар их боломжийг нээж байна. Интернетийн хэрэглээ огцом өслөө. Ялангуяа хөдөө орон нутагт Интернетийн болоод хөдөлгөөнт сүлжээг өргөнөөр нэвтрүүлснээр залуучуудад олон сайхан боломж нээгдэж байна. 2015 оны байдлаар Интернет хэрэглэгчдийн тоо 2.4 сая болсон нь хүн амын 81 хувийг эзэлж байна. Интернет хэрэглэгчдийн 80

орчим хувь нь Facebook-ээр холбогдож байгаа нь залуучууд хүсэл эрмэлзлэл, үзэл бодлоо харилцааны шинэ аргаар түгээх, залуучуудын улс төрийн оролцоог бэхжүүлэхэд чухал юм.

### **Хүний аюулгүй байдлыг бэхжүүлэх нь**

**Залуучууд хүчирхийлэлд өртөх эрсдлийг бууруулах, тэдэнд гэр бүл, нийгмийн бүлгүүдээс тууштай дэмжлэг үзүүлэх нь тэдний урт удаан, эрсдэлгүй, эрүүл, бүтээлч амьдрах нийгмийн болоод эдийн засгийн аюулгүй орчинг бий болгоход туслана.**

Өсвөр болоод нас бие гүйцэх явцдаа Монголын залуучууд хүчирхийлэл, зам, тээврийн болон үйлдвэрлэлийн осол, архидалт, нийгмийн тэгш бус үйлчилгээ, агаарын бохирдол зэрэг хүний аюулгүй байдлын олон эрсдэлтэй тулгарч байна. Эдгээр эрсдэл нь залуу хүмүүсийн нэр төр, амьдралын дадал хэв маягт сөргөөр нөлөөлж, хүссэнээрээ бүтээлчээр амьдрах эрх чөлөөгөө эдлэхэд, улмаар тэдний чадамжид аюул учруулдаг. Эрсдэл нь хүний халдашгүй байх язгуур эрхийг зөрчиж амгалан тайван байх эрх чөлөөг боомилохоос эхлээд залуучууд хариуцлагатай иргэний ёсоор улс төр, эдийн засаг, нийгмийн амьдралд оролцох чадамжийг ч сулруулдаг.

Монголд залуучууд өртөж болох хүчирхийллийн дараах ноцтой нийтлэг хэлбэрүүд оршсоор байна.

**Гэр бүлийн хүчирхийлэл:** Гэр бүлийн хүчирхийлэл нь жендэрийн ялгааг тод илэрхийлдэг. Цагдаагийн байгууллагын мэдээгээр 2015 онд гэр бүлийн хүчирхийллийн хохирогчдын 88.1 хувь нь эмэгтэйчүүд, 57.2 хувь нь 14-34 насны залуучууд байв. Иймээс холбогдох бүх талууд эмэгтэйчүүдийн эсрэг хүчирхийлэлтэй тэмцэхэд тууштай арга хэмжээ авах шаардлагатай байна.

**Дарамтлал:** Дэлхийн эрүүл мэндийн байгууллагаас (ДЭМБ) олон улсын хэмжээнд сургуулийн сурагчдын дунд

явуулсан эрүүл мэндийн судалгаагаар Монгол Улсад 13-25 насны залуусын 30 гаруй хувь, 16-17 насны хүүхдүүдийн 20 орчим хувь нь судалгаанаас өмнөх нэг сарын хугацаанд ямар нэгэн дарамтлалд өртөж байсан гэжээ.<sup>7</sup> Дарамтлалын явцад бие махбодид нь халдах, гэмтэл учруулах явдал сурагчдын дунд цөөнгүй тохиолдож байна. Мөн бага залуугаасаа хэн нэгнийг дарамтлах эсвэл дарамтлуулах нь хожим илүү ноцтой хүчирхийлэлд өртөх, эсвэл хүчирхийлэл үйлдэх үндэс болох эрсдэлтэй.

**Гэмт хэрэг:** Олон улсын жишгээс үзвэл гэмт хэргийг голдуу 15-30 насны эрэгтэйчүүд үйлддэг байна. Монгол Улсад 18-34 насны залуучууд гэмт хэргийн хохирогчдын тал хувь, гэмт хэргээр шийтгэгдсэн хүмүүсийн 75 хувийг тус тус эзэлж байна. Гэмт хэргийн түвшин хөдөө орон нутагтай харьцуулахад хотод өндөр байна.

**Бэлгийн мөлжлөгийн зорилгоор хүн худалдаалах:** Албадан хөдөлмөрлүүлэх, хүчээр гэрлүүлэх зорилгоор, мөн гэмт хэргийн шинжтэй хүн худалдаалах явдал олонтаа тохиолддог ч бэлгийн мөлжлөгийн зорилгоор хүн худалдаалах нь хүний наймааны хамгийн түгээмэл хэлбэр юм.<sup>8</sup> Хүний наймааны анхны тохиолдол 2000 онд бүртгэгдсэнээс хойш Монгол Улс хүний наймааны дамжин өнгөрөх болон гаргадаг орны тоонд ороод байна. Үүнд ганц бие ядуу эмэгтэйчүүд, боловсрол дулимаг залуу эмэгтэйчүүд өртөх эрсдэл өндөр байна.

**Амиа хорлох:** 2014 оны байдлаар амиа хорлохтой холбоотой нас баралтын түвшин (10000 хүн амд) эмэгтэйчүүдийн дунд 0.52, эрэгтэйчүүдийн дунд 2.67 байв. 15-29 насныхны дотор 100000 хүн амд ногдох амиа хорлолтын түвшин 14.3 гэсэн үзүүлэлтээр Монгол Улс дэлхийн 172 улсаас 69 дүгээрт оржээ.

**Цөөнхийн эсрэг ялгаварлан гадуурхалт:** Хүний эрхийн үндэсний комиссын 2012 оны тайланд дурдсанаар өөрийгөө лесбиян, гей, бисексуал, трансжендэр (ЛГБТ) гэдгийг хүлээн зөвшөөрсөн

хүмүүсийн 80 орчим хувь нь өмнөх гурван жилийн хугацаанд хүний эрхийн болон ялгаварлан гадуурхах аливаа нэг хэлбэрийн дарамтыг амссан байна.<sup>9</sup> ЛГБТ залуучууд гэр бүлээсээ ч гэсэн дэмжлэг авахад төвөгтэй байдаг байна.

Бусад насны бүлэгтэй харьцуулбал залуучууд хүчирхийлэлд хамгийн өртөмтгий байгаагийн гол нөхцөл шалтгааныг тогтооход хүндрэлтэй. Учир нь ядуурал, амьдралын хүнд нөхцөл, ажилгүйдэл, үйлчилгээний тэгш бус хүртээмж, хүчирхийлэлтэй тэмцэх хуулийн хэрэгжилт сул, эрчүүдийн хэвшмэл сөрөг хандлага, архидалт, хүний эрхийн ойлголт сул, хувь хүний зан төрхийн доголдол гэх зэрэг олон хүчин зүйл хүчирхийлэл гарахад нөлөөлдөг.

Гэр бүл, олон нийт залуучуудыг хүчирхийллээс хамгаалах, тэдний аюулгүй байдлыг хангахад чухал үүрэгтэй. Төр засаг, иргэний нийгмийн зүгээс хүчирхийлэлтэй тэмцэх чиглэлээр багагүй хүчин чармайлт гаргаж байна. Гэсэн хэдий ч цаашид аюулгүй орчныг бүрдүүлэх, хүчирхийллийн үндэс болж буй нийгэм, эдийн засгийн суурь хүчин зүйлүүдийг арилгахад чиглэсэн ихээхэн зүйл хийх шаардлагатай байна.

Залуучууд бол өөрчлөлтийн хөдөлгөгч хүч учраас нийгмийн оролцоо, мэдлэг ухамсараа дээшлүүлэх, нийгмийн үйлчилгээний хүртээмжийг сайжруулахыг шаардах, бодлого боловсруулах, хэрэгжүүлэх үйл ажиллагаан дахь оролцоогоо нэмэгдүүлэх замаар аюулгүй байдлаа бэхжүүлэх чадвараа сайжруулах боломжтой.

### **Залуучуудын талаарх бодлого, чиглэл**

**Монголын хүний хөгжилд гарсан ахиц дэвшил зарим талаар үр ашгаа өгсөн хэдий ч нийт залуу үеийнхэнд хүртээмж муутай байна. Тэдний чадамжийг дээшлүүлэх, хийх сонголт, хүртэх боломжийнх нь цар**

### **хүрээг нэмэгдүүлэхэд ихээхэн сорилт тулгарсаар байна.**

Илтгэлийн хүрээнд хийсэн судалгаа шинжилгээ, мэдээлэлд үндэслэн хүний хөгжлийн дөрвөн тулгуур асуудал тус бүрт хоёр, нийт найман бодлогын тэргүүлэх чиглэлийг тодорхойллоо. Үүнд:

1. *Залуучуудын чадамжийг хөгжүүлэхийн тулд* бүх шатанд чанартай боловсрол эзэмшихэд оршиж буй тэгш бус байдлыг бууруулах, амьдралын эрүүл хэв маягийг хэвшүүлэх;
2. *Залуучуудын боломжийг өргөжүүлэхийн тулд* тэдний хэрэгцээ шаардлагыг хангахуйц мэргэжлийн ур чадвар эзэмшихэд нь дэмжлэг үзүүлэх, тэдэнд зориулсан ажлын байр бий болгох;
3. *Залуучуудыг эрх мэдэлжүүлэхийн тулд* улс төрийн, иргэний болоод нийгмийн оролцоог нь хөхиүлэн дэмжих;
4. *Залуучуудын аюулгүй амьдрах орчинг сайжруулахын тулд* хүчирхийлэлд өртөх эрсдэлийг нь бууруулах, гэр бүл, хамт олны зүгээс үзүүлэх дэмжлэгийг нэмэгдүүлэх.

Залуучуудын талаарх төр засгийн бодлого, арга хэмжээ олон жилийн түүхтэй ч залуучуудын асуудлыг голдуу үндэсний болон салбарын бодлогуудад тусгах замаар хэрэгжүүлж ирсэн. Залуучуудын талаарх бодлого, хөтөлбөрүүд болон улс орны хөгжлийн томоохон зорилтууд өөр хоорондоо нягт уялдаагүйгээс эдийн засаг, улс төр, нийгмийн амьдралд оролцох залуучуудын оролцоо хязгаарлагдмал байна. Залуучуудын асуудлаарх хөтөлбөрүүдийн салбар хоорондын зохицуулалт сул, санхүүжилт ч хязгаарлагдмал байна. Залуучуудын талаарх бодлого, хөтөлбөрүүдийн үр нөлөөг сайжруулахын тулд Засгийн газар дараах чиглэлд анхаарал хандуулахыг зөвлөж байна. Үүнд:

1. *Үндэсний бодлого, төлөвлөлттэй илүү оновчтой уялдуулах:* залуучуудын талаарх бодлого нь үндэсний бодлого, төлөвлөлт, төсөв, тэдгээрийн хэрэгжүүлэлтийн тогтолцоонд сайтар суусан байх нь амжилтын үндэс болно;
2. *Залуучуудын талаарх бодлогын салбар хоорондын зохицуулалт:* Залуучуудын талаарх бодлогыг үр дүнтэй хэрэгжүүлэхийн тулд салбар, яамд хоорондын зохицуулалтыг үр ашигтай болгох, бүрэлдэхүүн хэсэг бүрийн уялдааг хангахын тулд нэгдсэн удирдлага зохицуулалттай байх;
3. *Залуучуудын асуудлаарх бодитой, харьцуулахуйц тоо мэдээлэл, судалгаатай болох:* нас, хүйсээр ангилсан тоон мэдээлэл цуглуулах, боловсруулах, сан бүрдүүлэх, гүнзгийрүүлсэн судалгаа шинжилгээ хийх нь залуучуудын талаар нотолгоонд суурилсан бодлого боловсруулахад нэн тустай;
4. *Залуучуудын оролцоог хөхиүлэн дэмжих:* Улс орныхоо ирээдүйн хөгжлийг тодорхойлох өргөн цар хүрээтэй асуудлаар улс төрийн шийдвэр гаргах түвшинд залуучуудын төлөөлөл хангалтгүй байгаагаас тэдний хэрэгцээ шаардлага бодлого шийдвэрт бүрэн тусгалаа олохгүй байна. Иймд ирээдүйн өнгийг тодорхойлогч залуучуудаа улс орныхоо хөгжлийн үйл хэрэгт идэвхитэй, санаачлагатай, ажил хэрэгчээр оролцохыг уриалж байна.

# ЗАЛУУЧУУДЫН ТАЛААРХ БОДЛОГО, ЧИГЛЭЛ


Энэхүү илтгэлээр залуучууд нь улс орны хөгжлийн салшгүй хэсэг, хөлгөгч хүч болохыг тунхаглаж байна. Илтгэлд Монголын залуучуудын эрүүл чийрэг, өндөр боловсролтой, ажилтай, эрх чөлөөгөө эдэлсэн, хариуцлагатай иргэд болцгоох боломж хийгээд тэдний өмнө тулгарч буй бэрхшээл сорилтод дүн шинжилгээ хийлээ. Ингэхдээ залуучуудын асуудлыг хүний хөгжлийн чадамжийн тухай үзэл баримтлалд суурилан судаллаа (бүлэг 1). Энэ үзэл баримтлал нь залуучууд улс орныхоо хөгжил дэвшилд хэр зэрэг хувь нэмэр оруулах нь тэдний чадамж буюу тэд урт удаан, эрүүл саруул, бүтээлчээр амьдарч чадаж байгаа эсэх, тэдэнд сонголт хийх боломж хэр нээлттэй байгаа зэргээс ихээхэн шалтгаална гэж үздэг. Чанартай боловсрол эзэмших, эрүүл саруул амьдрах бүхий л нөхцөлийг бүрдүүлэх нь хүний чадамжийн үзэл баримтлалын үндэс болно.

Сүүлийн жилүүдэд Монгол Улсын хүний хөгжилд ихээхэн дэвшил гарчээ. Гэсэн хэдий ч энэхүү ахиц дэвшлийн үр шимийг хүмүүс зарим талаар хүртсэн хэдий ч залуучуудад бүгдэд нь хүртээмжтэй байж чадсангүй. Энэхүү илтгэлд эдийн засаг, нийгмийн хөгжлийн үйл явцад манай залуучуудын оролцоо хэр байгаа, тэдний чадамжийг дээшлүүлэх, сонголт, боломжийг өргөжүүлэхэд тулгарч буй сорилтуудтай холбоотой олон асуудлыг судаллаа.

Илтгэлийн хүрээнд хийсэн судалгаа шинжилгээний үр дүн, мэдээллийг үндэслэн энэ бүлэгт өнөөгийн залуучуудад тулгарч буй сорилтуудыг шийдвэрлэх талаарх бодлогын өргөн хэлэлцүүлэг явуулахад тус болох дараах тэргүүлэх чиглэлүүд, зөвлөмжийг тодорхойлж гаргалаа. Эдгээр тэргүүлэх чиглэлүүдийг илтгэлийн нэгдүгээр бүлэгт өгүүлсэн дүн шинжилгээний хүрээний тулгуур асуудлын дагуу бүлэглэж, доорх 7.1-р зурагт үзүүлэв.

Зураг 7.1.

## Хүний хөгжлийн төлөөх Монгол Улсын залуучуудын талаарх бодлого



Чанартай боловсрол эзэмших боломж, эрүүл амьдрах чадвар нь хүний чадамжийг илэрхийлэх гол үзүүлэлт юм.

### Тэргүүдэх чиглэл 1: Боловсролын чанарыг сайжруулах

1990-ээд оны эдийн засгийн хямралаас үүдсэн бага, дунд боловсролын хамран сургалтын уналтыг эргүүлэн өндөр түвшинд хүргэж чадсан нь Монгол Улсын бахархууштай амжилтын нэг болсон. Эдүгээ тус улс бараг бүх хүүхдээ бага, дунд сургуульд хамран сургах түвшинд хүрээд байна. 2014 онд сургуульд орж буй хүүхэд цаашид 14.6 жил суралцах боломжтой байгаа нь хүний хөгжлийн түвшнээр өндөр улсуудын дунд сайн үзүүлэлт юм.

Сургуульд хамрагдалт ийнхүү өндөр түвшинд хүрсэн хэдий ч боловсрол эзэмших боломж залуучуудад хүйс, оршин суугаа газар, амьдралын түвшнээс нь шалтгаалан ялгаатай байна. Тухайлбал, хөдөөгийн хөвгүүдийн бүрэн дунд боловсролын хамрагдалтын түвшин бусад бүлгээс доогуур байна. Хөгжлийн бэрхшээлтэй хүүхэд залуучуудын дөнгөж 60 орчим хувь нь л ерөнхий боловсролын сургуульд суралцаж байна. Боловсролын чанар сургуульд хамрагдалтын түвшинд гарсан ахиц дэвшилтэй дүйцэхүйц хэмжээнд сайжирч чадсангүй. Чанартай боловсрол эзэмших боломж хотынхонд илүү, тэр тусмаа чинээлэг айлын хүүхэд залуучууд ийм боломжийг давуу хүртэх хандлагатай байна.

Ерөнхий боловсролын сургууль төгсөгчдөд ирээдүйн ажил мэргэжлээ сонгоход нь туслах мэргэжлийн зөвлөгөө дутмаг байгаагийн зэрэгцээ дээд сургуулиуд оюутан залуучуудад хөдөлмөрийн зах зээлд гарахад нь шаардагдах мэдлэг, ур чадварыг хангалттай олгож чадахгүй байна. Боловсролын чанарын энэхүү доголдол нь залуучуудын ирээдүйн хөдөлмөр

эрхлэлтийн төлөвт ихээхэн сөрөг нөлөө үзүүлж байна. Өнөөгийн дэлхий ертөнц бол улам бүр мэдлэгт суурилсан, ур чадвар, технологийн хөгжил, инновац шинэчлэлийг шаардах болсон. Иймд залуучуудыг оршин суугаа газар, хүйс, амьжиргааны түвшнээс нь үл хамааран чанартай мэдлэг боловсрол эзэмших тэгш боломжоор хангах нь Монголын ирээдүйд маш чухал ач холбогдолтой.

### Үйл ажиллагааны чиглэл

Залуучуудын чадамжийг хөгжүүлэх, тэднийг цаашдын амьдралд нь бэлтгэхийн тулд төр, засгаас дараах арга хэмжээг авах шаардлагатай.

- Дунд сургуулиас нь эхлэн хүүхэд, залуучуудын бүтээлч сэтгэлгээ, эрэгцүүлэн бодох чадварыг хөгжүүлэх:
  - Сургалтын хөтөлбөр, заах арга, сурах бичгийг олон улсын жишигт нийцүүлэн боловсролын үндэсний стандартыг тогтвортой хэрэгжүүлэх;
  - Сургуулиудын дэд бүтэц, материалаг баазыг шинэчлэн сайжруулах;
  - Мэдээлэл харилцааны технологийн дэвшлийн хүртээмж эрс нэмэгдэж байгаа давуу байдлыг сайтар ашиглах боломжийг залуучуудад олгох, Интернет, нийгмийн цахим сүлжээг тасралтгүй суралцах хэрэгсэл болгон ашиглахыг дэмжих замаар гадаад хэлний болон мэдээллийн технологийн мэдлэг, ур чадвараа дээшлүүлэх боломж залуу хүн бүрт нээлттэй байх нөхцөлийг бүрдүүлэх;
  - Төгсөгчиддөө зориулсан мэргэжлээ сонгоход нь зөвлөх үйлчилгээг дунд сургуульд бий болгох.

- Дээд боловсролын сургалтын агуулгыг хөгжлийн чиг хандлага, хэрэгцээтэй уялдуулан хөгжүүлэх:

- Өндөр ур чадвартай мэргэжлийн багш нартай, сургалтын орчин сайтар бүрдсэн зохистой тооны, чанартай дээд сургуулиудтай байх;
- Мэргэжлийн чиг баримжаа олгох сургалтын агуулгыг залуучууд ажлын туршлага хуримтлуулах, хөдөлмөрийн зах зээлийн өөрчлөгдөж буй эрэлт хэрэгцээгхангахуйц ур чадвар эзэмшүүлэхэд чиглүүлэх;
- Хөгжлийн бэрхшээлтэй залуучуудын дээд боловсрол эзэмших боломжийг нэмэгдүүлэх.

## **Тэргүүдэх чиглэл 2: Амьдралын эрүүл хэв маягийг дэмжих**

Хүн амын дундаж наслалт (төрөх үеэс нь тооцсон) нэмэгдэж байгаа хэдий ч 1990-ээд оноос хойш 15-24 насны залуучуудын дундаж наслалт зөвхөн нэг жилээр нэмэгдсэн ба 25-34 насныхны дундаж наслалтад өөрчлөлт гараагүй байна. Түүгээр ч барахгүй 15-34 насны эрэгтэйчүүдийн дундаж наслалт 1990-2010 онд буурсан байна. Цаашилбал, залуучуудын нас баралтын түвшин 2010 оноос хойш бүх насны бүлэгт, нас баралтын шалтгаан бүрээр өсөх хандлагатай байна. Мөн эрэгтэйчүүдийн нас баралтын эрсдэл бүх насны бүлэгт эмэгтэйчүүдийнхээс 2-3 дахин өндөр байна. Осол, гэмтэл, хордлого болон гадны бусад нөлөөлөл зэрэг нь залуучуудын нас баралтын зонхилох шалтгаан болж байна.

Залуучуудын дунд эрүүл бус хооллолт, хөдөлгөөний хомсдол, архи, тамхи хэрэглэх, хамгаалалтгүй бэлгийн харьцаанд орох, түүнчлэн зам, тээврийн осол зэрэг эрсдэлт хүчин зүйлүүд түгээмэл байгаа нь залуучуудын сэргийлэх боломжтой өвчин эмгэг тусахгүй байх, БЗДХ авах, төлөвлөөгүй үедээ жирэмслэх, зуурдаар амь насаа алдах зэргээс өөрийгөө хамгаалах

чадварыг сулруулж, хожим халдварт бус өвчнөөр өвчлөх үндсийг тавих магадлалтай.

## **Үйл ажиллагааны чиглэл**

Холбогдох бүх талууд залуучуудын эрүүл амьдрах хэв маягийг дэмжих хэрэгтэй байна. Төр засаг, холбогдох бусад байгууллагууд дараах арга хэмжээг авах шаардлагатай.

### **Бодлогын түвшинд**

- Архи, тамхитай холбоотой хууль, дүрэм, журмыг чанд хэрэгжүүлэх;
- Өсвөр үеийнхэн болон залуучуудын эрүүл мэнд, хөгжлийн талаарх үндэсний стратегийг боловсруулан хэрэгжүүлэх, залууст ээлтэй, тэдний эрхийг хүндэтгэсэн, нууцлалыг чанд хадгалсан үйлчилгээг өргөжүүлэх;
- Эрүүл мэндийн бодлогод залуучуудын бэлгийн болон нөхөн үржихүйн эрүүл мэнд хийгээд эрхийн асуудалд онцгой анхаарал хандуулах, ялангуяа гэр бүл төлөвлөлт болон БЗДХ-ын чанартай тусламж үйлчилгээ авах боломжийг нэмэгдүүлэх;
- Эрүүл хүнс хэрэглэх, зохистой хооллох, тухайлбал, давс, хийжүүлсэн ундаа, транс өөх тосны хэрэглээг багасгахыг дэмжсэн бодлого, үндэсний стандартуудыг боловсруулан мөрдүүлэх.

### **Татвартай холбоотой арга хэмжээ**

- Архи, тамхины татварыг нэмэгдүүлж, орлогыг залуучуудын хөгжил, эрүүл мэндийг дэмжих үйл ажиллагаанд зарцуулах;
- Залуучуудад зориулсан спортын клуб, фитнес төвүүд болон чөлөөт цагаа зөв боловсон өнгөрүүлэх бусад байгууламжийг байгуулахад бизнес эрхлэгчдэд татварын хөнгөлөлт үзүүлэх.

### **Үйлчилгээ үзүүлэх талаар**

- Өсвөр үеийнхэн болон залууст ээлтэй үйлчилгээ, тухайлбал, бэлгийн болон

нөхөн үржихүйн эрүүл мэндийн үйлчилгээг өргөжүүлэх, залуучуудыг татах, хэрэглээг нэмэгдүүлэх; өсвөр үеийн эрүүл мэндийн төвүүдийг залуучуудын хэрэгцээ шаардлагад нийцүүлэн хөгжүүлэх.

#### *Сурталчилгааны аян болон спортын арга хэмжээ*

- Архи, тамхины эрүүл мэндийн хор уршгийг таннулах, амьдралын эрүүл хэв маягийг дэмжих мэдээлэл сурталчилгааны аянг үндэсний хэмжээнд тогтмол зохион байгуулахад хувийн хэвшил, иргэний нийгмийн болон залуучуудын байгууллагуудтай хамтран ажиллах;
- Сургуулиудын амьдрах ухаанд суурилсан боловсролын чанарыг сайжруулж өргөжүүлэх, бие бялдрын боловсролыг дунд сургуульд заавал үзэх хичээл болгох;
- Спортын уралдаан тэмцээнийг ивээн тэтгэх хувийн хэвшлийн санаачлагыг өрнүүлэх;
- Иргэний нийгмийн байгууллагуудаас залуучуудад үйлчилгээ үзүүлэх дэмжлэгт орчныг бүрдүүлэх.

#### *Сургууль, олон нийт болон иргэний нийгмийн байгууллагууд дараах үйл ажиллагааг хэрэгжүүлэх*

- Өндөр эрсдэлтэй, хүрч ажиллахад төвөгтэй өсвөр насныхан, залуучууд, ялангуяа эрэгтэйчүүдийн амьдралын эрүүл дадал хэв маягийн талаарх ойлголтыг дээшлүүлэхэд нийгмийн маркетингийн шинэлэг арга болон нийгмийн цахим сүлжээг ашиглах, зан үйлийг өөрчлөх шинэлэг, үр дүнтэй хөтөлбөрүүдийг хэрэгжүүлэх;
- Бүх шатны сургуульд амьдрах ухаанд суурилсан эрүүл мэндийн чанартай боловсрол олгох

сургалтын хөтөлбөрийг нэвтрүүлэх, оюутнуудын амьдралын эрүүл хэв маягийг дэмжих.

#### *Гэр бүл дараах үйл ажиллагааг хэрэгжүүлэх*

- Жимс, хүнсний ногоог аль болох өргөн хэрэглэж, гэр орондоо эрүүл хооллолтын дэглэмийг дадал болгох;
- Гэр орноо тамхигүй орчин болгох, дам тамхидалтын хор уршгаас зайлсхийх зорилгоор гэртээ тамхи татахгүй байх дадал хэвшүүлэх;
- Эцэг, эх, ах, эгч нар нь эрүүл амьдрах хэв маягийг сахиж, хүүхдүүд, дүү нартаа үлгэр дууриал болох;
- Төрсөн өдөр, цагаан сар, хурим найр зэрэгт архи, согтууруулах ундаа хэрэглэхгүй байх, бага хэрэглэх;
- Гэр орондоо амьдралын эрүүл хэв маяг, түүний дотор бэлгийн боловсролын талаар нээлттэй ярилцах эерэг уур амьсгалыг бий болгох.

#### *Залуучуудын өөрсдийн хүчин чармайлт маш чухал тул тэд дараах үйл ажиллагааг хэрэгжүүлэх боломжтой*

- Архи, тамхины хэрэглээгээ багасгах, зогсоох;
- Олон төрлийн эрүүл хүнс хэрэглэж занших;
- Амьдрах ухаан, ур чадвар эзэмшүүлэх сургалтад хамрагдах;
- Спорт, биеийн тамираар хичээллэх, ажил, сургуульдаа дугуйгаар болон явган явах, фитнес клубт хичээллэх зэргээр бие бялдраа чийрэгжүүлэх, идэвхтэй амьдралын хэв маягийг хэвшүүлэх.



## Тулгуур 2: Боломжийг нэмэгдүүлэх талаар

Залуучуудад амьдралынхаа хүсэл мөрөөдлийг биелүүлэх боломжийг өргөжүүлэхийн тулд тэдний мэргэжлийн ур чадварыг дээшлүүлэх, хөдөлмөр эрхлэлтийг нэмэгдүүлэх нь хамгийн чухал.

### Тэргүүлэх чиглэл 3: Хөдөлмөрийн зах зээлийн хэрэгцээ шаардлагад нийцсэн ур чадвартай болгох

### Тэргүүлэх чиглэл 4: Залуучуудад зориулсан ажлын байр олноор бий болгох

Зохистой, бүтээмжтэй ажилтай болоход нь хөдөлмөрийн зах зээлийн эрэлт нийлүүлэлтийн нийцгүй байдал, мөн тэдний сургуулиар олж авсан мэдлэг ур чадвар нь хөдөлмөрийн зах зээл дээрх хэрэгцээ шаардлагыг хангаж чадахгүй байгаа явдал, ажлын байрны хомсдол, ялангуяа хөдөө орон нутагт ажил хийх боломж хязгаарлагдмал байгаа, ажлын байр байлаа ч залуучуудын санаанд нь нийцэхгүй байх, ажил мэргэжлээ сонгоход нь туслах мэргэжлийн зөвлөлгөө өгөх үйлчилгээ дутмаг байгаа зэрэг олон асуудал залуучуудын өмнө тулгарч байна.

Хэдийгээр сүүлийн жилүүдэд эдийн засаг эрчимтэй өсч байсан ч түүнийг хөдөлмөр эрхлэлтийн мэдрэмжийг сайжруулах хөшүүрэг болгох, ялангуяа хүн амын томоохон хэсэг болох залуучуудын хөдөлмөр эрхлэлтийг нэмэгдүүлэхэд чиглүүлэхэд ихээхэн сорилттай тулгарч байна. 20-24 насны залуучуудын ажилгүйдлийн түвшин 17 хувьтай байгаа нь ажилгүйдлийн улсын дундаж түвшнээс хоёр дахин өндөр байна. Ажилгүй залуучуудын олонх нь жил, түүнээс дээш хугацаагаар ажил хайж байна.

Амьдралын боломж нь тааруу залуучууд сургуулиас ажилд шилжих үед илүү хүндрэл бэрхшээлтэй тулгардагас хурдахан орлоготой болохын тулд таарсан ажилдаа орох болдог. Эдгээр залуучуудын нилээд нь боловсрол,

ур чадвартаа үл нийцэх тааралдсан ажилдаа орох явдал түгээмэл байна.

Дээд сургуульд болон төгсөлтийн дараах сургалтад эмэгтэйчүүд эрэгтэйчүүдээс тооны хувьд илүү хамрагдаж байгаа боловч тэдний энэ давуу байдал нь хөдөлмөр эрхлэх, сайн ажилд орох хөшүүрэг болж чадахгүй байна. Ажилд орохоосоо өмнө гэр бүлтэй болсон залуу эмэгтэйчүүдэд ажил олох, эсвэл эргээд ажилдаа ороход илүү төвөгтэй байдгаас тэд удаан хугацаагаар ажилгүй байх явдал олонтаа тохиолдож байна.

Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн (залуучуудыг оролцуулан) 80 орчим хувь нь эдийн засгийн идэвхгүй байгаа бөгөөд эдийн засгийн идэвхтэй хэсгийн дийлэнх нь хувиараа хөдөлмөр эрхэлж байгаа нь хөгжлийн бэрхшээлтэй хүмүүс хөдөлмөр эрхлэхэд нэлээд саад бэрхшээл байгааг харуулж байна.

### Үйл ажиллагааны чиглэл

Залуучуудын хөдөлмөр эрхлэлтийг эрчимтэй нэмэгдүүлэхийн тулд тэдний ажил мэргэжлийн ур чадварыг хөгжүүлэхэд хөрөнгө оруулах нь Монгол Улс байгалийн баялагт суурилсан эдийн засгаас мэдлэгт суурилсан эдийн засагт шилжихэд маш чухал. Залуучуудын хөдөлмөр эрхлэх боломжийг нэмэгдүүлэх, тогтвортой ажлаар хангах замаар хүний хөгжлийг түргэсгэхийн төлөө төр засгаас дараах арга хэмжээ авах шаардлагатай.

### Бодлогын түвшинд

- Ажил хөдөлмөрийн өөрчлөгдөж буй шинж төрхийг харгалзсан, Монголын залуучуудад тулгарч буй онцлог хүндрэл бэрхшээлийг даван туулахад чиглэсэн залуучуудын хөдөлмөр эрхлэлтийн үндэсний стратегийг хэрэгжүүлж, залуучуудыг хүний хөгжлийг түргэсгэхүйц, бүтээмж өндөртэй, хангалттай цалинтай, санаанд нь нийцсэн ажлын байраар хангах өргөн боломжийг бүрдүүлэх;

- Макро эдийн засгийг дэмжих бодлого стратегид залуучуудын хөдөлмөр эрхлэлт, тухайлбал, дээд боловсролтой залуучуудад тохирсон ажлын байр олноор бий болгох асуудлыг тусгах, залуучууд уул уурхай, түүнийг дагалдах салбаруудад ажиллаж өндөр цалинтай, тогтвортой ажлын үр шимийг хүртэхийг дэмжих;
- Нийгмийн хөгжлийг түргэсгэхийн сацуу, тус салбарт ажлын байр олноор бий болгоход чиглэсэн нийгмийн чиглэлийн бизнесийг дэмжих;
- Залуучуудын хөдөлмөр эрхлэлтийн бодлогыг үндэсний хөгжлийн стратегид тусган амжилттай хэрэгжүүлж буй бусад улсуудын туршлагыг олон улсын хөгжлийн түншүүдийн дэмжлэгтэйгээр судлан нэвтрүүлэх;
- МСҮТ-д суралцагчдад олгох тэтгэлэг нэмэгдэж, мэргэжилтэй ажилчдын эрэлт хэрэгцээ байсаар атал сүүлийн жилүүдэд МСҮТ-ийн элсэлт буурч буй шалтгааныг судлах, шаардлагатай бол бодлогод зохих өөрчлөлт оруулах.

#### *Сургалтын агуулга ба ур чадварыг дээшлүүлэх*

Өнөөгийн хэрэгжүүлж буй залуучуудын хөдөлмөр эрхлэлтийн болон ажил эрхлэхэд нь шаардлагатай ур чадварыг хөгжүүлэх сургалтын хөтөлбөрүүдийг ялангуяа, хөдөө орон нутагт өргөжүүлэх;

#### *Эдийн засгийн олон тулгуурт хөгжил*

- Уламжлалт мал аж ахуй болон газар тариалангийн салбарт орчин үеийн технологийн дэвшлийг нэвтрүүлэх, мал эмнэлгийн үйлчилгээг сайжруулахад хөрөнгө оруулах, залуучуудын хөдөө аж ахуйн салбар дахь оролцоог нэмэгдүүлэхийн тулд хүлэмжийн аж ахуй болон хөдөө аж ахуйн боловсруулах үйлдвэрлэлийг дэмжих;

- Монголын далайд гарцгүй байгаа сул талыг нөхөх, залуучуудын нөөц боломж, оюуны чадавхийг үр бүтээмжтэй ашиглахын тулд нанотехнологи, биотехнологи зэрэг мэдлэгт суурилсан ирээдүйтэй салбаруудыг хөгжүүлэх.

#### *Залуучуудын бизнес эрхлэлт*

- Хувийн хэвшлийнхэнтэй хамтран сургалтын хөтөлбөрүүд хэрэгжүүлэх замаар залуучуудад бизнес эрхлэх мэдлэг, чадвар олгох, залуу бизнес эрхлэгчдийг санхүүгийн тогтвортой үйлчилгээнд өргөнөөр хамруулах.

#### *Аж үйлдвэр болон дээд боловсролын уялдаа*

- Залуучуудын ажил мэргэжлийн ур чадварыг хөдөлмөрийн зах зээлийн хэрэгцээ шаардлагад нийцүүлэхийн тулд ажил олгогчид, үйлдвэр аж ахуйн газрууд, дээд сургуулиуд, МСҮТ-үүдийн хоорондын уялдаа холбоог бэхжүүлэх механизмыг бий болгох;
- Бизнесийн салбараас чадварлаг оюутнуудад сургалтын тэтгэлэг олгох явдлыг дэмжих, ингэхдээ уул уурхайн инженер зэрэг хэрэгцээтэй мэргэжилд түлхүү анхаарах;
- Бизнесийн инкубаториуд, дээд сургуулиудын сургалтын баазыг аж үйлдвэрийн зангилаа төв, паркуудад байршуулж, мэдээлэл, харилцаа, технологийн дэвшилтэт дэд бүтэцтэй болгох.

#### *Залуу эмэгтэйчүүд болон хөгжлийн бэрхшээлтэй залуучуудын хөдөлмөрийн зах зээлд орох боломжийг нэмэгдүүлэх*

- Хүүхэд асрах үйлчилгээ бий болгож эмэгтэйчүүдийг ажилдаа эргээд орох боломжоор хангаж байгаа хувийн хэвшлийн аж ахуйн нэгж байгууллагуудад татварын хөнгөлөлт үзүүлэх гэх мэт оновчтой бодлого боловсруулах;
- Хувийн хэвшлийн аж ахуйн нэгжүүд хөгжлийн бэрхшээлтэй

залуучуудыг ажилд авах, тэдний тусгай хэрэгцээнд нийцсэн дэд бүтэц бий болгох (тухайлбал налуу зам тавих) явдлыг дэмжих зохих урамшуулал хөнгөлөлт үзүүлэх; хөгжлийн бэрхшээлтэй залуучуудын чадамжийг дээшлүүлэх, тэднийг дээд боловсрол, техникийн мэдлэг эзэмших боломжийг өргөжүүлэх;

- Цалин хөлстэй болон цалин хөлсгүй ажлын үр ашгийн тэнцвэргүй байдлыг шийдвэрлэх. Үүний тулд бодлогын түвшинд дараах дөрвөн арга хэмжээг авах: (а) цалин хөлсгүй асран халамжлах ажлын ачааллыг багасгах, хуваалцах; (б) хүүхдийн цэцэрлэгийн тоог нэмэгдүүлэх, гэр хороололд нийгмийн чанартай үйлчилгээ авах боломжийг

нэмэгдүүлэх зэргээр зохих бодлого, үйл ажиллагааны үр дүнг дээшлүүлэх, хэвшмэл ойлголт, хэм хэмжээг өөрчлөх замаар залуу эмэгтэйчүүд цалин хөлстэй ажил хийх нөхцөл боломжийг өргөжүүлэх; (в) нялх хүүхэдтэй аавуудад цалинтай чөлөө олгох гэх мэт албан болон гэрийн ажлын зохистой тэнцвэрийг хангах бодлогыг хэрэгжүүлэх; (г) жендэрийн үүрэг, хариуцлагын талаарх ойлголт, хандлагыг өөрчлөх;

- Эмэгтэйчүүд цөөн ажиллаж байгаа мэргэжлүүдээр тэдэнд чанартай дээд боловсрол эзэмших боломжийг өргөжүүлэх, эмэгтэйчүүд давамгайлж байгаа мэргэжлийн салбаруудад эрэгтэйчүүдийн оролцоог дэмжих.

### Тулгуур 3: Залуучуудыг эрх мэдэлжүүлэх талаар

Залуучуудын улс төр, нийгэм, олон нийтийн оролцоо нь тэднийг эрх мэдэлжүүлэх үйл явцыг түргэтгэдэг.

#### Тэргүүлэх чиглэл 5: Улс төрийн оролцоог дэмжих

#### Тэргүүлэх чиглэл 6: Нийгмийн оролцоог өргөжүүлэх

Улс төрчид, улс төрийн намуудын сүүлийн жилүүдийн үйл ажиллагаа нь залуучуудын улс төрийн институтцад итгэх итгэлийг бууруулж байна. Судалгаанд хамрагдсан залуучуудын гуравны нэг нь улс төрчдөд итгэх итгэл суларсан нь тэдний улс төрийн идэвх буурахад нь нөлөөлсөн гэж үзжээ.

Хотын болон амьдралын боломж тааруу залуучуудын улс төрийн институтцад итгэх итгэл бүр бага байна. Залуучууд мөн засаглалын үйл ажиллагааны чанарт сэтгэл дундуур байдаг аж. Үр дүнгүй, ёс төдий зүйл хэмээн үздэг учир тэд сонгосон гишүүдтэйгээ харилцах талаар тэр бүр идэвх гаргадаггүй ажээ. Залуучуудын ердөө 15 хувь нь л нутаг орныхоо өмнө тулгамдсан асуудлыг шийдвэрлэхийн төлөө лобби хийх

зэргээр улс төрчдөд нөлөөлөх идэвхтэй ажиллагаанд хамрагдсан байна.

Гэхдээ идэвх нь суларсан хэдий ч залуучууд улс төрөөс бүр холдоогүй, улс төрийг сонирхсон хэвээр байна. Монголчууд ерөнхийдээ ардчилалыг хөгжүүлж байгаагаараа бахархдаг. Залуучууд сонгуулийн насны хүн амын 45 хувийг эзэлдэг бөгөөд тэдний 45 орчим хувь нь сонгуульд идэвхтэй оролцдог. Тэд хариуцлагатай төр засгийг хүсч, амалсандаа хүрч тодорхой үр дүн гаргахыг шаардаж байна.

Цаашилбал, залуучууд иргэний нийгмийн байгууллагууд болон сайн дурын үйл ажиллагаагаар дамжуулан нийгмийн амьдралд идэвхтэй оролцож байна. Тэдний оролцоог дайчлах, мэдээлэл түгээх, өөр хоорондоо харилцаа холбоо тогтооход Интернет ихээхэн үүрэг гүйцэтгэж, гол хэрэгсэл нь болж байна. Залуучуудын нийгмийн оролцоо нь тэдний асар их эрч хүч, өөдрөг үзэл санааны илэрхийлэл юм. Залуус нутаг орноо хөгжүүлэхэд илүү үр дүнтэй өргөн оролцох боломж, дэмжлэг, удирдамж чиглэлийг эрэлхийлж байна.

### Үйл ажиллагааны чиглэл

Бодлого боловсруулагчид, улс төрийн удирдагчид залуучуудын тэдэнд итгэх итгэл суларч байгаад дүгнэлт хийж, энэ нь залуучуудын ажил амьдралд нөлөөлөх аливаа бодлого боловсруулахад тэднийг оролцуулах, хөгжлийн үйл явцад залуучуудын өргөн оролцоог хангахын тулд засаглалыг сайжруулах шаардлага хэмээн үзэх хэрэгтэй. Залуучуудын улс төрийн өргөн оролцоог хангахын тулд дараах арга хэмжээ авах нь нэн чухал болно:

- Иргэний боловсролын шинэчлэлийн хүрээнд залуучуудын ардчилалын боловсролыг сайжруулах;
- Сонгуульд анх саналаа өгөх гэж байгаа залуучууд болон сонгуульд огт оролцдоггүй хүмүүст чиглэсэн

сонгогчдын боловсролын зорилтот хөтөлбөрийг хэрэгжүүлэх;

- Холбогдох бодлого, хөтөлбөрийн хүрээнд залуучуудын нийгмийн оролцоог идэвхжүүлэхэд чухал ач холбогдолтой үндэсний болон орон нутгийн сайн дурын үйл ажиллагааны тогтолцоо, бүтцийг бий болгох;
- Залуучуудын амьдрах ухаан, манлайлал, иргэншлийн мэдлэг, ур чадварыг хөгжүүлэх өргөн цар хүрээтэй үйл ажиллагаанд оролцоход дэмжлэг үзүүлэх албан болон албан бус боловсролын механизмыг бий болгох;
- Залуучуудын хүсэл эрмэлзэл, үнэт зүйлсийн ойлголтын талаарх динамик судалгааг өргөжүүлэх.

## Тулгуур 4: Хүний аюулгүй байдлыг бэхжүүлэх талаар

Хүчирхийлэлд өртөх эрсдэлийг бууруулах болон гэр бүлийн бат бэх дэмжлэг нь залуус урт удаан, эрүүл саруул, аюулгүй, бүтээлч амьдрах таатай орчинг бүрдүүлэхэд тустай.

### Тэргүүдэх чиглэл 7: Хүчирхийлэлд өртөх эрсдэлийг бууруулах

### Тэргүүдэх чиглэл 8: Гэр бүл, хамт олны дэмжлэгийг бэхжүүлэх

Залуучууд нь гэр бүлийн хүчирхийлэл, дарамтлал, гэмт хэрэг, амиа хорлохыг завдах, хүний наймаа, үзэн ядалтаас үүдэлтэй гэмт хэрэг зэрэг янз бүрийн эрсдэлд өртөх явдал байсаар байна. Эдгээр эрсдэл нь залуучуудын сургууль, ажил, олон нийтийн газар, гэр орны аюулгүй байдалд заналхийлж байна. Залуучуудын хүчирхийлэлд өртөх эрсдэл өндөр байх тусам хүний хөгжлийг түргэсгэх нөөц бололцоонд нь сөргөөр нөлөөлдөг.

Залуучуудыг хүчирхийллийн хохирогч эсвэл үйлдэгч болохоос хамгаалахад гэр бүл маш чухал үүрэгтэй. Мөн залуус

сургуулиа төгсөөд анхны тогтвортой ажилд орох хүртэлх шилжилтийн үеийн санхүүгийн гол эх үүсвэр нь тэдний гэр бүл юм. Энэ хугацаанд залуучууд төр засгаас ямар нэгэн санхүүгийн дэмжлэг авдаггүй тул тэд эцэг, эх, ах, эгч болон бусдаас ихээхэн хамааралтай байна.

Гэхдээ бүх гэр бүл хүүхэддээ үргэлж дэмжлэг үзүүлээд байж чаддаггүй. Нөгөө талаар гадаад, дотоод шилжих хөдөлгөөний улмаас гэр бүлийн бүтцэд ихээхэн өөрчлөлт гарч байна. Гэр бүл салсан болон бэлэвсэн эцэг, эхтэй залуучуудад гэр бүлийн дэмжлэг хязгаарлагдмал байна.

### Үйл ажиллагааны чиглэл

Залуучуудад аюулгүй орчинг бүрдүүлэхэд холбогдох бүх талууд санаа тавих ёстой. Төр засаг болон холбогдох байгууллагууд залуучуудын хүчирхийлэлд өртөмтгий байдлыг бууруулахад чиглэсэн дараах арга хэмжээг хэрэгжүүлэх хэрэгтэй байна.

- Энэ асуудлаар эрх зүйн зохицуулалтыг боловсронгуй болгож, холбогдох хууль тогтоомжийг чанд хэрэгжүүлэх;
- Бүх хүмүүс нийгмийн үйлчилгээнд тэгш хамрагдах нөхцөлийг бүрдүүлэх;
- Аймаг, сумдад залуучуудын хөгжлийн төв, клубуудыг байгуулж, залуучууд нийгмийн амьдрал идэвхтэй оролцох, чөлөөт цагаа зөв боловсон өнгөрүүлэх боломжийг нэмэгдүүлэх;
- Архи, согтууруулах ундааны зохисгүй хэрэглээг бууруулах оновчтой хөшүүргүүдийг ашиглах;
- Асуудалд ул суурьтай хандаж үр дүнтэй бодлого боловсруулахад шаардагдах тоо мэдээг цуглуулах, судалгаа хийх;
- Ядуу өрхийн залуучуудад сургуулиас ажилд шилжих хугацаанд нь нийгмийн халамжийн зорилтот тэтгэлэг олгодог болох. Уг тэтгэлэгийг сургууль төгссөний дараах нэг жилийн хугацаанд мөнгөн тусламж хэлбэрээр залуучуудад шууд олгох, аль эсвэл бага орлоготой өрхийг татвараас чөлөөлөх хэлбэрээр зохион байгуулж болох юм.

Иргэний нийгэм болон олон нийт дараах үйл ажиллагааг хэрэгжүүлэх:

- Залуучуудын нийгмийн үйл хэрэгт оролцох боломжийг өргөжүүлэх;
- Мэдлэг, ойлголт, ухамсрыг дээшлүүлж, хандлагыг өөрчлөх;
- Залуучуудын асуудлаарх ойлголтыг дээшлүүлэх сургалтуудыг, ялангуяа хууль сахиулах байгууллагуудын дунд явуулах.

Гэр бүлийн зүгээс дараах үйл ажиллагааг хэрэгжүүлэх:

- Залуучуудын хүсэл тэмүүлэл, тэдний онцлог асуудлыг ойлгож, дэмжлэг үзүүлэх, таатай орчинг бүрдүүлэх.

Залуучууд дараах үйл ажиллагааг хэрэгжүүлэх:

- Нийгмийн сүлжээ, тухайлбал, Facebook-ийн бүлгээрээ дамжуулан мэдлэг, ойлголтоо дээшлүүлэх; нийгмийн оролцоогоо нэмэгдүүлэх, спорт, бусад арга хэмжээнд өргөн оролцох зэргээр чадамжаа ухамсартайгаар хөгжүүлэх, аюулгүй байдлаа бэхжүүлэх.

## **Залуучуудын талаарх үндэсний бодлогыг боловсруулах, хэрэгжүүлэхэд тулгарч буй сорилтууд**

Улс орны засгийн газрууд залуучуудын тулгамдсан асуудлууд хийгээд эрэлт хэрэгцээг нь шийдвэрлэхийн ач холбогдлыг хүлээн зөвшөөрч, залуучуудад тусгайлан чиглэсэн бодлого, хууль тогтоомжийг гарган хэрэгжүүлж байна. Эдүгээ дэлхийн 198 улсаас 122 нь залуучуудын талаарх үндэсний бодлоготой болсон нь 2013 оныхоос 50 хувиар нэмэгдсэн байна. Монгол Улс мөн залуучуудын хөгжлийн цогц бодлого боловсруулах талаар хүчин чармайлт гаргаж байна. Энэхүү илтгэл нь залуучуудад тулгарч буй тодорхой асуудлуудыг тойрон хэлэлцэх боломж олгож, залуучуудын талаарх

төрийн бодлогын зөв шийдвэр гаргах, олон нийтийн мэдлэг мэдээллийг нэмэгдүүлэхэд хувь нэмрээ оруулна гэдэгт найдаж байна. Залуучуудын үндэсний бодлогыг боловсруулах, хэрэгжүүлэхэд эн тэргүүнд анхаарвал зохих зарим асуудлыг зөвлөмж болгож байна.

### **Үндэсний хөгжлийн бодлого, төлөвлөлттэй уялдуулах**

Залуучуудын талаарх бодлого нь үндэсний бодлого, төлөвлөлт, төсөв болон хэрэгжилтийн механизмтай сайтар уялдсан байх нь амжилттай хэрэгжих үндэс болно. Манай улс

залуучуудынхаа асуудлыг салбарын бодлогын хүрээнд шийдэж ирсэн боловч залуучуудын хөгжлийн асуудлууд үндэсний бодлого, төлөвлөлтөд зохих ёсоор бүрэн тусгагдаагүй, төсөвт сайн суухгүй явж ирсэн.

Залуучуудын асуудлыг Монгол Улсын Тогтвортой хөгжлийн зорилготой нягт уялдуулах хэрэгтэй байна. Тогтвортой хөгжлийн бүхий л зорилго залуучуудын асуудалд хамаатай, ялангуяа хүн амыг эрүүл саруул, сайн сайхан амьдрах нөхцлөөр хангах (зорилго 3), хүн бүрт чанартай боловсролыг тэгш, оролцоотойгоор олгож, насан турш сурч боловсрох боломжийг бүрдүүлэх (зорилго 4), жендэрийн тэгш байдлыг хангах, бүх охид, эмэгтэйчүүдийг эрх мэдэлжүүлэх (зорилго 5), тасралтгүй, оролцоот, тогтвортой эдийн засгийн нөсөлтийг дэмжих, нийт хүн амыг бүтээмжтэй, баталгаатай орлоготой хөдөлмөр эрхлэлт, зохистой ажлаар хангах (зорилго 8), тогтвортой хөгжилд хүрэхийн тулд амгалан тайван, оролцоот нийгмийг цогцлоон, шударга ёсыг хангаж, үр нөлөөтэй, хариуцлагатай, оролцоот институцийг бүх шатанд бий болгох (зорилго 16) зэрэг зорилгууд нь залуучуудын чадамжийг хөгжүүлэх, боломжийг өргөтгөх, эрх мэдэлжүүлэх, аюулгүй байдлыг бэхжүүлэхэд шууд нөлөөтэй.

Монгол Улс 2030 он хүртэлх Тогтвортой хөгжлийн үзэл баримтлалаа боловсруулж 2016 оны эхээр УИХ-раа баталсан билээ. Энэхүү илтгэлийг боловсруулах явцад залуучуудын асуудлаар хийсэн олон цуврал хэлэлцүүлгүүд, НҮБ-ын “Бидний хүсч буй дэлхий ертөнц” дэлхийн судалгаанд оролцсон залуучуудын дэвшүүлсэн асуудлууд, тэдгээрийг шийдвэрлэх арга замын талаарх мэдээлэл Монгол Улсын Тогтвортой хөгжлийн үзэл баримтлалд тусгагдах онцгой боломж, нөхцөл болсон юм.<sup>10</sup>

## Залуучуудын асуудлаарх салбар дундын зохицуулалт

Залуучуудын талаарх бодлого нь салбарын яамд хооронд нарийн зохицуулалттай байх ёстой. Залуучуудын асуудал нь салбар дундын асуудал бөгөөд нилээд хэсэг нь чиг үүргийн яамдын хэрэгжүүлэх үйл ажиллагаатай шууд холбоотой. Иймээс залуучуудын бодлогын амжилт салбар хоорондын үр дүнтэй зохицуулалтаас ихээхэн хамаарна. Үүнээс улбаалан мөн бүрэлдэхүүн хэсэг бүрийн дам нөлөө болон харилцан дэмжих нөлөөг нь харгалзан залуучуудын бодлогыг яамд хамтран хэрэгжүүлэх нь илүү үр дүнтэй байх болно.<sup>11</sup>

*Дам нөлөө гэдэг нь нэг салбарт хэрэгжүүлсэн үйл ажиллагаа нь нөгөө салбарт нөлөөлөхийг хэлнэ. Тухайлбал, залуучуудын дундархидалт буурах нь тэдний эрүүл мэндийг сайжруулаад зогсохгүй, гэмт хэрэг, замын хөдөлгөөний осол буурахад мөн нөлөөлнө.*

*Харилцан дэмжих нөлөө гэдэг нь хэрэв эрүүл мэндийн эрсдлийг бууруулах үйл ажиллагааг мэдлэг, ур чадварын сургалттай холбон хэрэгжүүлбэл залуучуудын ажил олох, тогтвортой ажиллах боломж нэмэгдэнэ, түүнчлэн гэр бүлийн хүчирхийлэлд өртөх магадлал багатай, гэр бүлийн дэмжлэг сайтай залуучууд тогтвортой ажил эрхлэхэд шаардлагатай мэдлэг, ур чадвар эзэмших илүү боломж бүрдэнэ.*

Нөгөө талаар залуучуудын талаарх ганцхан нийтлэг бодлогод хүн амын ийм том бүлгийн бүх асуудлыг хамрах боломжгүй. Иймд Засгийн газар залуучуудын бодлогыг хэд хэдэн стратеги буюу дэд бодлогод хувааж, залуучууд гэсэн том бүлэгт хамаарах янз бүрийн хэрэгцээ бүхий дэд бүлгүүдийн асуудлыг илүү үр дүнтэй шийдвэрлэх хувилбарыг авч үзэж болох юм.

## **Залуучуудын асуудлаар нарийвчилсан судалгаа хийх, бодитой тоо мэдээлэл цуглуулах шаардлага**

Монголд залуучуудын талаарх бодитой, харьцуулахуйц тоо мэдээлэл хомс байгааг энэхүү илтгэлд нэг бус удаа тэмдэглэсэн. Бодитой тоо мэдээлэл цуглуулахад саад болж байгаа нэг хүчин зүйл бол тус улсад залуучуудын насны ангилал тодорхой бус байгаа явдал юм. Энэ асуудлыг үндэсний хэмжээнд хэлэлцэж зөвшилцөнө гэдэгт найдаж байна.

Залуучуудтай холбоотой янз бүрийн асуудлуудаар судалгаа шинжилгээ, ялангуяа нийгмийн нарийвчилсан судалгаа ихээхэн дутмаг байна. Олон асуудлаарх тоо мэдээллийг Улсын бүртгэл, статистикийн газраас гаргаж байгаа ч гүнзгийрүүлсэн судалгаа, дүн шинжилгээ хомс байна.

Энэхүү илтгэлд хөндсөн зарим асуудлууд, тухайлбал, шилжих хөдөлгөөнтэй холбоотойгоор гэр бүлийн бүтэц, харилцаанд гарч байгаа өөрчлөлт; нийгмийн мэдээллийн цахим сүлжээ өргөн дэлгэрч байгаа нь залуучуудын дунд шинэ харилцаа холбоо, хамтлаг, бүлгүүд үүсэхэд хэрхэн нөлөөлж байгаа талаар; залуучуудын ядуурал; гэр хорооллын амьдралын нөхцлөөс үүдэн залуучуудад тохиож буй асуудлууд зэрэг олон асуудлын мөн чанарыг тодорхойлоход бодитой тоо мэдээлэл чухал байна.

Дээрх олон асуудлаарх судалгаа, шинжилгээний ажлыг өргөжүүлэх нь Монголд залуучуудад ээлтэй, нотолгоонд суурилсан бодлого боловсруулахад ихээхэн түлхэц болно.

## **Залуучуудын оролцоо**

Улс төрийн шийдвэр гаргах түвшинд Монголын залуучуудын төлөөлөл хязгаарлагдмал байгаа учир тэдний санал шаардлага тэр бүр хүрэх цэгтээ хүрэхгүй байна. 2008 оноос хойших УИХ-д 35 хүртэлх насны ганц л гишүүн

сонгогджээ. Тэгэхээр залуучуудын УИХ дахь төлөөлөл бодит байдал дээр эмэгтэйчүүдийнхээс ч цөөн байна. Одоогийн УИХ-ын 76 гишүүдийн 11 нь эмэгтэйчүүд байгаа билээ.<sup>12</sup>

Үүнээс үзэхэд шинэчлэлийг хэрэгжүүлэхэд залуучуудын нөлөөлөл сул байжээ хэмээн дүгнэж болох юм. Үүнд нэг талаар залуучуудын улс төрийн институтууд итгэх итгэл нь сул, улс төрийн оролцоо нь идэвхгүй байсан явдал нөлөөлсөн байж болох юм. Нөгөө талаар залуучуудын улс төрийн идэвх сул байгаа ч тэдний нийгмийн үйл хэрэгт оролцох оролцоо сайн байгаа нь талархууштай хэрэг юм. Гэхдээ нийгмийн оролцоо улс төрийн оролцоог орлож чадахгүй. Залуучуудын улс төрийн оролцоо буурч байгаа нь анхаарал хандуулах ёстой асуудлуудын нэг юм.

Залуучуудын нийгмийн идэвх, оролцоог улам бүр хөхиүлэн дэмжих хэрэгтэй. Төр засгийн болон бусад байгууллагууд залуучуудтай илүү үр дүнтэй харилцах арга барилд суралцах, хөтөлбөрүүдээ тэдний сонирхолд илүү нийцтэй болгох, тэдний асар их авьяас чадварыг үнэлж түншээ болгон хамтран ажиллах хэрэгтэй. Ингэснээр холбогдох бүх байгууллагууд илүү оролцоот хөгжил дэвшлийн төлөө нөөц боломжоо чөлөөтэй хөгжүүлэхэд нь залуучуудаа дэмжихийн зэрэгцээ тэдний бодол санаа, зориг эрмэлзлэл, бүтээлч сэтгэлгээний үр шимийг хүртэх болно.

Бодлого боловсруулагчид зөвхөн залуучуудын бодлогын асуудалд бус, улс орныхоо хөгжлийн өргөн цар хүрээтэй бодлого чиглэлийг тодорхойлохдоо залуучуудынхаа дэмжлэгийг авах хэрэгтэй. Хөгжлийн алсын хараагаа тодорхойлох, ирээдүйн сайн сайхныг хамтдаа цогцлооход залуучуудын илүү хүчтэй дуу хоолой хэрэгтэй байна.

Энэ бол залуучуудын тухай илтгэл юм. Үүгээр залуучуудад тулгарч буй сорилт бэрхшээл, тэдний оролдлого, чармайлт, бухимдал улмаар тэдний

хүсэл эрмэлзэл, итгэл найдвар, ололт амжилтыг судлан баримтжуулж тэд Монгол улсынхаа хөгжил дэвшилд илүү их хувь нэмэр оруулж хурдацтай өөрчлөгдөж буй дэлхий ертөнцөд өөрсдийн гэрэлт ирээдүйг цогцлоогчид болохыг тэмдэглэж байна.

Монгол Улсын Хүний хөгжлийн үндэсний энэхүү илтгэлээр залуучуудын асуудалд холбоотой тоо баримт, мэдээллийг судлан шинжилж тодорхой санал, дүгнэлт зөвлөмжийг дэвшүүлээ. Илтгэлд хөндсөн асуудлуудыг цаашид бодлого боловсруулагчид, холбогдох талууд, хөгжлийн түншүүд, хамгийн гол нь залуучууд хамтдаа хэлэлцэж, шийдвэрлэх аваас Монголын

залуучуудын хөгжилд тус илтгэлийн оруулах хамгийн том хувь нэмэр болох юм.

Залуучууддаа анхааралаа хандуулах цаг болжээ. Маргаашийн залуучууд ч аль хэдийн эсэн мэнд өсч торниж байна. Эдийн засгийн хүртээмжтэй, тогтвортой өсөлт, өндөр чанартай, тэгш хүртээмжтэй боловсрол, амьдралын эрүүд хэв маяг болон сайн сайхан аж байдал, тогтвортой, бүтээмжтэй, зохистой ажил хөдөлмөр, эрх мэдэл, аюулгүй байдлын баталгаат орчин нөхцлийг залуучууддаа бүрдүүлэх нь залгамж үеийнхээ төлөө сайн сайхан ирээдүйг цогцлооход шийдвэрлэх чухал ач холбогдолтой.



# Тайлбар, тэмдэглэл

## Ерөнхий тойм

- 1 НҮБХАС, 2014а.
- 2 Дэлхийн банк, 2015.
- 3 Энэ хэсэг дэх ишлэл болон бусад мэдээллийг Дэлхийн банкны “Үнэлгээ, хяналт” сэтгүүлээс авав, Вашингтон хот, <http://www.worldbank.org/en/country/mongolia/overview> (2015.11.16).
- 4 Сен, 1999, х. 291.
- 5 ХӨСҮТ, 2015.
- 6 НҮБХХ, 2015, х. 3.
- 7 ДЭМБ, 2013 он.
- 8 ХЭҮК, ХЭХТ, 2002.
- 9 ХЭҮК, 2012.

## Залуучуудын талаарх бодлого, чиглэл

- 10 “Өөрийн бодлоо илэрхийл” (мэдээллийн сан), Миний дэлхий ертөнц 2015, НҮБ, Нью Йорк, <http://data.myworld2015.org/?country=Mongolia>.
- 11 Асуудлыг дэлхийн банкны мэдээлэлд (2007) дурьдсан.
- 12 ҮСХ, 2014а.

# Ашигласан материалын жагсаалт

**ХӨСҮТ (Халдварт өвчин судлалын үндэсний төв, Эрүүл Мэндийн Яам).** 2015. “Surveillance Report”. Global AIDS Response Report. Улаанбаатар.

**МУ-ын ХЭҮК (МУ-ын Хүнийн Эрхийн Үндэсний Комисс).** 2012. “Монгол дахь хүний эрх, эрх чөлөөний талаарх 11 дэх илтгэл”. Улаанбаатар.

**МУ-ын ХЭҮК (МУ-ын Хүний Эрхийн Үндэсний Комисс), ХЭХТ (Хүний эрх хөгжлийн төв).** 2002. “Монгол дахь эмэгтэйчүүд, хүүхдийн наймаа: өнөөгийн байдал”. 11 дүгээр сар. Улаанбаатар. [http://www.childtrafficking.com/Docs/nhrm\\_2002\\_mongolia\\_trafficking\\_report\\_3.pdf](http://www.childtrafficking.com/Docs/nhrm_2002_mongolia_trafficking_report_3.pdf). Ашигласан 2015.12.22.

**ҮСХ (Үндэсний Статистикийн Хороо).** 2014а. Монгол Улсын Статистикийн Эмхтгэл, 2013. Улаанбаатар.

**Сен, Амартия.** 1999. Хөгжил бол эрх чөлөө. Нью Йорк: Алфред Кнофф.

**НҮБХАС (НҮБ-ын Хүн Амын Сан).** 2014а. Дэлхийн хүн амын байдал, 2014; 1.8 тэрбумын хүчин чадал: Өсвөр насныхан, залуучууд болон ирээдүйн шинэчлэл. Нью Йорк.

**НҮБХХ (Нэгдсэн Үндэстний Байгууллагын Хөгжлийн хөтөлбөр).** 2015а. Хүний Хөгжлийн Илтгэл, 2015: Хүний хөгжлийн төлөө ажиллала. Нью Йорк. <http://hdr.undp.org/en/content/human-development-report-2015-work-human-development>.

**ДЭЗФ (Дэлхийн Эдийн Засгийн Форум).** 2013. “Хүний капиталын илтгэл”. Үнэлгээний илтгэл. Мерсер, Женев.

**Дэлхийн Банк.** 2015. “Монголын эдийн засгийн шинэчлэл”. Илтгэл 101064 (11 дүгээр сар). ДБ, Вашингтон. [http://www-wds.worldbank.org/external/default/WDSContentServer/WDSP/IB/2015/11/19/090224b0831edad4/1\\_0/Rendered/PDF/Mongolia000EconomicUpdate.pdf](http://www-wds.worldbank.org/external/default/WDSContentServer/WDSP/IB/2015/11/19/090224b0831edad4/1_0/Rendered/PDF/Mongolia000EconomicUpdate.pdf).



## Монгол Улсын эдийн засгийн үндсэн үзүүлэлтүүд, 2000–2015 он

Үзүүлэлт	2000	2005	2010	2011	2012	2013	2014	2015
ДНБ (2010 оны зэрэгцүүлэх үнээр, тэрбум төгрөг)	–	–	9 756.6	11 443.6	12 853.4	14 350.7	15 482.3	15 837.7*
ДНБ (оны үнээр, тэрбум төгрөг)	1 224.1	3 041.4	9 756.6	13 173.8	16 688.4	19 174.2	22 227.0	23 166.8*
ДНБ, салбараар (%)	100	100	100	100	100	100	100	100
Хөдөө аж ахуй, ойн аж ахуй, загасны аж ахуй	27,4	19,8	11,7	10,3	11,2	13,4	13,3	13,6*
Аж үйлдвэр	22,2	32,5	33,2	31,3	30,8	30,5	31,5	31,4*
Үйлчилгээ	50,4	47,7	55,1	58,4	58	56,1	55,2	55,0*
ДНБ-ний өсөлт (%)	1,1	7,3	6,4	17,3	12,3	11,6	7,9	2,3*
ДНБ-ний бүтэц, зарлагаар (%)	100	100	100	100	100	100	100	100
Эцсийн хэрэглээ	85,7	67,3	67,9	63,7	66,5	69,3	69,6	70,8*
Хөрөнгийн нийт хуримтлал	27,5	37,5	42,1	58,2	55,9	53,3	35,2	26,3*
Цэвэр экспорт	-13,2	-4,8	-10	-21,9	-22,4	-22,6	-4,8	2,9*
Улсын нэгдсэн төсвийн нийт тэнцвэржүүлсэн орлого (тэрбум төгрөг)	351,1	837,9	3 122.5	4 468.2	4 957.8	5 986.9	6 316.5	5 976.1*
Улсын нэгдсэн төсвийн нийт зарлага (тэрбум төгрөг)	429,7	764,6	3 080.7	4 997.0	5 993.8	6 164.7	7 144.6	7 136.9*
Төсвийн нийт тэнцвэржүүлсэн тэнцэл (тэрбум төгрөг)	-78,6	73,3	41,8	-528,8	-1 036.0	-177,8	-828,1	-1 160.8*
Улсын нэгдсэн төсвийн орлогын ДНБ-д эзлэх хувь	28,7	27,5	32	33,9	29,1	31,2	28,4	25,8*
Улсын нэгдсэн төсвийн зарлагын ДНБ-д эзлэх хувь	35,1	25,1	31,6	37,9	35,9	32,1	32,1	30,8*
Эрүүл мэнд	3,8	2,6	2,5	2,5	2,5	2,7	2,9	2,5*
Боловсрол	6,7	5,1	5,1	4,8	5,6	8,7	8,9	4,3*
Төсвийн нийт тэнцвэржүүлсэн тэнцэлийн ДНБ-д эзлэх хувь	-6,4	2,4	0,4	-4	-6,8	-1,1	-3,7	-5,0*
Гүйлгээнд гаргасан бэлэн мөнгө (М2), тэрбум төгрөг, жилийн эцсийн байдлаар	258,4	1 140.1	4 680.0	6 412.2	7 613.7	9 454.9	10 635.8	10 050.2*
Зээлийн өрийн үлдэгдэл (тэрбум төгрөг)	66 756.7	859 851.8	3 264 778.0	5 641 233.7	6 988 365.1	10 764 170.3	12 502 525.7	11 695 763.6*
Зээлийн өрийн үдэгдэлийн өсөлт (%)	-13,9	41,7	23	72,8	23,9	54	16,1	-6,5*
Аймгуудын (Улаанбаатар ороогүй) зээлийн өрийн үлдэгдэл	–	177 959.1	675 044.9	1 223 622.3	1 540 899.5	2 301 719.2	2 765 674.7	2569925*
Улаанбаатарын зээлийн өрийн нийт үлдэгдэл эзлэх хувь		20,7	20,7	21,7	22	21,4	22,1	22,0*
Хэрэглээний үнийн индекс (%), 2010.XII=100	39,9	55,6	100	108,9	124,2	139,7**	154,3	157,2
Экспорт, сая ам. доллар	535,8	1 064.9	2 908.5	4 817.5	4 384.7	4 269.1	5 774.3	4 669.3*
Импорт, сая ам. Доллар	614,5	1 184.3	3 200.1	6 598.4	6 738.4	6 357.8	5 236.7	3 797.5*
Гадаад худалдааны тэнцэл, сая ам доллар	-78,7	-119,4	-291,6	-1 780.9	-2 353.7	-2 088.7	537,6	871.8*

\* – Урьдчилсан дүн

\*\* – Худалдаалагдсан махны үнийн индексийг тооцсон.

Эх сурвалж: Монгол Улсын Статистикийн эмхтгэл, Статистикийн сарын товхимол, БСҮХ, Улаанбаатар хот.

## **МОНГОЛ УЛСЫН ХҮНИЙ ХӨГЖЛИЙН ИЛТГЭЛҮҮД 1997-2016**

**1997** Хүний Хөгжил

**2000** Төрийг шинээр зүглүүлэхүй

**2003** Хот хөдөөгийн ялгаатай байдал

**2007** Хөдөлмөр эрхлэлт, ядуурал

**2011** Эмзэг байдлаас тогтвортой хөгжил рүү: Байгаль орчин, хүний хөгжил

**2016** Ирээдүйн сайн сайхны төлөө: Монгол Улсын хөгжилд залуучуудын оролцоо